ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

5 дугаар баг, Дархан сум, Дархан-Уул аймаг, 45063
Утас/Факс: (976) 7037-4303
Цахим шуудан: darkhan.emg@gmail.com
Цахим хуудас: http://www.darkhan-uul.mohs.mn

2026.06.24 № 319

танай ______ -ны № ______ -т

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ
САЛБАРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАРТ

Эрүүл мэндийн газрын 2026 оны хагас жилийн гүйцэтгэлийн тайлан болон Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлтийг эхний 5 сарын байдлаар гарган хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 65 хуудастай.

ДАРГА Б.ЭРДЭНЭТУЛГА

4526030408

4526290408

2026.06.20 M.Ж

http://www.darkhan-uul.mohs.mn
darkhan.emg@gmail.com
(976) 7037-4303
5 · 45063

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

**Зорилго:Хүүхдийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.**

2026.06.10.

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин (хагас жил) | Хэрэгжилт | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **1.НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР** | | | | | | | |
| 1.1.Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулан, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох, мэдлэг хандлагыг дээшлүүлэх сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах | | | | | | | |
| 1.1.1 | Эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж байгаа хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллана. | - | Хэрэгжилтийн хувь | 93% -. | 60% | Сэтгэцийн эрүүл мэнд, Эрүүл шүд, Иргэний эрүүл мэндийн боловсрол дээшлүүлэх, Эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд, Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтыг бууруулах, Эрүүл мэндийн салбар дахь хүүхдийн эрх хамгаалал, Жендерт суурилсан болон гэр бүлийн хүчирхийлэлттэй тэмцэх сэргийлэх, Цар тахлын дараах, эрүүл мэндийн салбарын тогтвортой байдлыг хангах, Хорт хавдраас сэргийлэх, хянах, Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд, Орчны эрүүл мэнд, Эрүүл, аюулгүй сургууль зэрэг зорилтот бүлгийн эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжих 12 арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлж, хэрэгжилтийн дундаж 62% байна. 2026 онд шинээр ЭМС-дын 2026.03.06-ны өдрийн "Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах арга хэмжээний төлөвлөгөө" А/82 дугаар тушаал /2026- | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2028 он/, ЭМС-дын 2026.05.28-ны өдрийн “БЗДХ, ХДХВ, ДОХ-оос сэргийлэх, хянах арга хэмжээний төлөвлөгөө” А/189 дугаар тушаал /2026-2029 он/ зэрэг 2 арга хэмжээний төлөвлөгөө шинээр батлагдан ирсэн | |
| 1.1.2 | Хүн амд эрүүл зан үйл төлөвшүүлэх, халдварт бус өвчлөлийг бууруулах чиглэлээр эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл, сургалт, сурталчилгааг зохион байгуулна. | - | Сургалт, сурталчил-гаанд хамрагдсан хүний тоо | 36127 | 20000 | • 2026 оны эхний хагас жилийн байдлаар Зонхилон тохиолдох Халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалтад 26421 хүн хамрагдсан. Эрүүл мэндийн газрын цахим хуудаст Эрүүл мэндийн салбарын хэмжээнд зохион байгуулсан үйл ажиллагааны мэдээллийг 103 удаа, Халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх 48 төрлийн цахим зөвлөмж боловсруулан байршуулсан. Эрүүл мэндийн газрын цахим хуудасны дагагч 17892, нийт хандалт 280000 хүн.<br>• Мөн орон нутгийн хэвлэл мэдээллийн DBS, RGB телевизүүд, Цэц.мн сайт, Аймгийн мэдээлэл технологийн албатай хамтран 87 мэдээ бэлтгэсэн. Үүнээс үйл ажиллагаа-28, Тодруулга ярилцлага-7, Халдварт өвчин-25, Халдварт бус-17 мэдээ тус тус байна. Нийт мэдээний давтамж нэг мэдээ 3 удаагийн давтамжтай эфирээр цацагддаг. Миний мэргэжил эмч 2 контент, Эрүүл идэвхтэй амьдралын хэв маягыг сурталчлах цуврал 1 контент бэлтгэн иргэд олон нийтэд хүргэсэн байна. Эрэгтэйчүүд, Өсвөр үеийн эрүүл мэнд, Дархлаажуулалт, архины хэрэглээнээс татгалзая, Томуу томуу төст өвчин, Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдөр сэдвүүдээр 28 удаагийн рийл бэлтгэн иргэдэд түгээсэн.<br>• Монгол улсын Засгийн газрын 2001 оны тогтоолын дагуу “Нийгмийн эрүүл мэндийн нэрэмжит 18 удаагийн тэмдэглэлт өдрийг зохион байгуулж, үүнд өдөрлөг 11 удаа, аян 7 удаа зохион байгуулж, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд 24157 хүнийг хамруулсан байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах, тандах ажлыг эрчимжүүлэх, цаашид авах арга хэмжээг тодорхойлох зорилгоор зөвлөгөөнийг 2026.03.21-22 өдрүүдэд Эрүүл мэндийн байгууллагуудын удирдах ажилтнууд, холбогдох эмч мэргэжилтнүүд 42 хүн, СӨББ, ЕБС-ийн 40 эмч нарт зохион байгуулсан. | |
| 1.1.3 | Ерөнхий боловсролын 6-11 ангийн сурагчдыг "Үе тэнгийн -Эерэг нөлөөлөгч сургагч"-аар бэлтгэн Өсвөрийн эмч клубын үйл ажиллагааг идэвхижүүлнэ. | УТХО | Бэлтгэгдсэн сургагч багш | 225 | 250 | Эрүүл мэндийн газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Боловсролын газар Улаанзагалмай хороо хамтран Тусгайлсан хөтөлбөрөөр "Үе тэнгийн сургагч багш" бэлтгэх **Ерөнхий боловсролын 26 сургуулийн 8-11 ангийн 251 бүлгийн эрэгтэй-1, эмэгтэй-1** сонгон сургалтыг 2026.04.15-17-ны өдрүүдэд Хүүхэд хөгжлийн ордонд **502** сурагчдыг хамруулсан зохион байгуулсан. Аймгийн хэмжээнд Ерөнхий боловсрол ын 26 сургуулиудын **78 гишүүд**ийг сонгон "**Эмч клуб**"-ыг Эрүүл мэндийн газрын дэргэд байгуулж, үе тэнгийхэндээ эрүүл мэндийн боловсрол олгох нөлөөллийн клуб байгуулагдлаа. | 100% |
| 1.1.4 | "Эрүүл шүд" арга хэмжээний хэрэгжилтийн хангаң, шүд угаалтын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулна. | ОНХО | BASS-н аргыг эзэмшсэн хүүхэд | - | СӨБ-ын 2-5 насны хүүхдийн хамрагдалт >25 | 1.Аймгийн ХГБХХГ-с ирүүлсэн судалгаанд үндэслэн ЭМГ, НЭ, Хувийн хэвшлийн шүдний эмнэлгүүд хамтран 2026.05.01-ны өдрөөс Эрсдэлт нөхцөлд амьдарч буй 51 хүүхэд, Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй, эрсдэлт нөхцөлд амьдарч буй 11 хүүхэд нийт 62 хүүхдийг үнэ төлбөргүй шүдний үзлэгт хамруулж, бүрэн эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулж байна.<br><br>2. Гүүднэйборс ОУТББ-н Дархан-Уул аймаг дахь Мангирт ОНХХ-н Хүүхэд ивээн тэтгэх хөтөлбөрт бүртгэлтэй 2-18 насны 1845 хүүхдийг 2026.04.08-04.17-ны өдрүүдэд хүүхдийн нарийн мэргэжлийн эмч, шүдний эмч, арьс харшлын эмч, өсөлт | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөгжлийн үнэлгээ хосолсон цогц урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгт хамруулж, 1845 хүүхдэд шүдийг хамгаалах нэмэлт эрдэсжүүлэлтийг үнэ төлбөргүй түрхсэн.<br><br>3. Эрүүл шүд арга хэмжээний хүрээнд “Дэлхийн амны хөндийн өдөр”-ийн хүрээнд Дархан-Уул аймаг дахь СОС Хүүхдийн хотхонд амьдарч буй хүүхдүүдэд Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг хамтран 2026.03.31-ны өдөр амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох, шүдний өвчлөлийг эрт илрүүлэх, шүд арчилгааны зөв дадал хэвшүүлэх урьдчилан сэргийлэх үзлэг, эрүүл мэндийн боловсрол олгох сургалт хосолсон үйл ажиллагааг зохион байгуулсан. СОС Хүүхдийн хотхон нь 3-17 насны нийт 45 хүүхэдтэй ба үзлэгт нийт хамрагдвал зохих 45 хүүхдээс 41 хүүхэд хамрагдаж, хамрагдалтын хувь 91.1%-тай. Үзлэгийн дүнд 34 хүүхэд амны хөндийн өвчлөл, шүдний цоорoлтой, 7 хүүхэд өвчлөлгүй эрүүл 7 илэрч, эрүүл 7 (17%) хүүхдэд шүд эрдэсжүүлэх хамгаалах фторт түрхлэг түрхсэн.<br><br>4. Эрүүл Шүд арга хэмжээний хүрээнд Нэгдсэн эмнэлгийн Поликлиник – I тасгийн шүдний кабинетаас 2026.02.02-ны өдрөөс 2026.05.15-ны өдрийн хугацаанд сургуулийн өмнөх боловсролын 1, 18, 21, 22, 23, 24, 25, 26, 27, 29-р цэцэрлэгийн бага бүлгээс бэлтгэл бүлгийн нийт 1655 хүүхдийг цэцэрлэгт суурилсан явуулын шүдний үзлэгт хамруулсан. Үзлэгээр 1655 хүүхдийн 480 (29%) эрүүл, 1175 (71%) цоорoлтой байна. Эрүүл бүлгийн 480 хүүхдийн 113 (23.5%)-д шүдийг хамгаалах нэмэлт эрдэсжүүлэлт, фтор түрхлэг үнэ төлбөргүй түрхэж ажилласан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.1.5 | Осол гэмтлээс сэргийлэх үйл ажиллагаанд салбар дундын хамтын ажиллагааг сайжруулж, Аюулгүй жолоодлого-эрсдэлгүй алхам арга хэмжээ зохион байгуулна. | - | Хамрагдсан хүний тоо | 1500 | 2000 | Эрүүл мэндийн газар, Цагдаагийн газар, Автотээврийн газар, Улаанзагалмайн хороо Дархан дахь салбар хамтран **“Аюулгүй жолооч-Шуурхай тусламж”** Зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, ослын үед үзүүлэх анхны, амилуулах суурь тусламж үзүүлэх мэдлэг, чадвар олгох аяныг зохион байгуулах ажлын хэсгийн уулзалтыг зохион байгуулсан. Аянг 2026.04.25-05.25 хүртэл зохион байгуулахаар нэгдсэн төлөвлөгөөг аянг хэрэгжүүлэх мэргэжлийн байгууллагууд хамтран 5 удаа 263 жолооч нарыг сургалтад хамруулсан байна. Үүнд:<br>1. Аймгийн Цагдаагийн газрын 87 бие бүрэлдэхүүнийг Ослын үеийн анхны тусламжийн үндсэн мэдлэг, ур чадвар олгох чадавхжуулах сургалтад хамруулсан.<br>2. “Пуужинт сум”, “Хөхөөн хөндийн” “Алтан жолоо” “Мандах хурд” зэрэг 4 Авто сургалтын байгууллагад суралцаж буй нийт 176 жолооч нарт Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах дадал, ослын үед зөв арга хэмжээ авах чадвар, анхны тусламжийн мэдлэгийг эзэмшүүлэх сургалт, дадлага сургалтад хамруулсан.<br>Осол гэмтлээс сэргийлэх сургалтыг 783 иргэдэд, өсвөр насны 287 хүн, 206 эцэг эхчүүд, Ажлын байрны сургалтыг 7 удаа 287 албан хаагчид сургалтад хамрагдсан. | 78% |
| 1.1.6 | Нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох, жирэмсний хяналтыг сайжруулах, ОНБТХ-оор хангах үйл ажиллагааг зохион байгуулна. | - | Хамрагдсан хүний тоо | 1500 | 2000 | • Эх хүүхдийн нөхөн үржихүйн арга хэмжээ 5 зорилт 12 үйл ажиллагаа хэрэгжилт 50%-тай байна.<br>• Нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох сургалтад нийт 2123 хүн хамрагдсан. Үүнд:392 оюутан залуус, 31 орон гэргүй иргэд, 369 жирэмсэн эхчүүд, Коллежид суралцдаг 161 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | охид, Оюуны-Ирээдүй сургуулийн 236 охид, үе тэнгийн сургагч 502 сурагчид, ажлын байрны 432 албан хаагчид тус тус хамрагдсан байна.<br>• Дархан-Уул аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн санаачилгаар “Хүүхэд-Хайр-Ирээдүй” нөхөн үржихүйн эрүүл мэнд сэдвээр Эрүүл мэндийн газар, Цагдаагийн газар, ХГБХХ-ын газар, Онцгой байдлын газар, Боловсролын газрын сургалт, мэдээллүүдийг нэгтгэж, ЕБ-н 1, 12, Монгол-Оюу, ШУТИС-ийн лицей, Дархан дээд сургуулийн эцэг эх асран хамгаалагч нарт сургалт хийж мэдээ, мэдээллээр хангаж ажиллаа. Сургалтад ЕБ-ын 5 сургуулийн 560 эцэг, эх, асран хамгаалагч нар хамрагдсан.<br>• Эрүүл мэндийн газраас Хүүхдийн мэргэжилтэн, эмийн мэргэжилтэн, Эх барих нөхөн үржихүйн эмч нар хяналт үнэлгээний багаар 3 сум, 5 өрхийн эрүүл мэндийн төвд 2026.03.17-2026.03.20ны өдрүүдэд ажиллаж, Өндөр тунт А аминдэм, олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэл, жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлэлт, захиалга, худалдан авалт, түгээлт, хэрэглээг. Эхний улирлын байдлаар үзэхэд 641 жирэмсэн эх хяналтад байгаагаас 403 эхэд ОНБТХ-ыг олгож, хамрагдалт 63 хувь байна. Нэмэлтээр 682 ОНБТХ-ийн захиалга хийгдсэн. Харин 0-5 насны хүүхдэд болон хөхүүл эхийн ОНБТХ-захиалга хийгдээгүй тул 0-5 насны хүүхэд, хөхүүл эхийн ОНБТХ-оор хангах нөөц, хэрэглээг зохион байгуулах зөвлөмж өгч ажиллав.<br>• Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэгтэй хамтран эмэгтэйчүүдийн эмч нартай хамтран 7 хоног бүр Даваа, Лхагва, Баасан гариг “Эсэн мэнд амаржихуй” сургалтыг зохион байгуулж, 369 жирэмсэн эх, залуу гэр бүл хамрагдсан. Сургалтад нийт 598 жирэмсэн эхийн 61.7% хамрагдсан байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • Аймгийн Эрүүл мэндийн газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвтэй хамтран 2026.02.11-12-ны өдрүүдэд нөхөн үржихүй насны хөгжлийн бэрхшээлтэй 727 хүнийг эмэгтэйчүүдийн нарийн мэргэжлийн эмч үзлэг, ЭХО, эсийн шинжилгээнд хамруулсан. Үзлэгээр умайн миом-4, үтрээний үрэвсэл-5, сувганцрын архаг завсрын эдийн өөрчлөлт-1, биеийн юмгүйдэл-1, цэвэршилтийн хам шинж-2, үргүйдэл-1, умайн хүзүүний хавьдрын урьтал-2 илрүүлж, мэргэжлийн эмчийн зөвлөгөө өгч, ХӨСҮТ-рүү 2 хүн илгээсэн.<br>• Өсвөр нас түүнийг дагаж гарах өөрчлөлт, шилжилтийн нас, бэлгийн бойжилт, бэлгийн ариун цэвэр сахих, өсвөр нас түүнийг дагаж гарах өөрчлөлт, шилжилтийн нас, бэлгийн бойжилт, бэлгийн ариун цэвэр сахих сэдвээр 27 Ерөнхий боловсролын сургуулиудын өсвөр үеийн сурагчдыг 2835 хүүхдийг хамруулан зохион байгуулсан. | |
| 1.1.7 | Хүн амд орчны эрүүл мэндийг хамгаалахад мэргэжлийн байгууллагуудтай хамтран сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулна. | - | Хэрэгжилтийн хувь | 80% | 50% | • Эрүүл мэндийн газар, ГҮҮД НЭЙБОРС ОУТББ хамтран ажиллах гэрээний дагуу “Дэлхийн усны өдөр”-ийг Байгаль орчны газартай хамтран Дархан сумын Ерөнхий боловсролын 4-р сургуулийн ахлах ангийн 150 сурагчдад “Ус ба хүйс” уриан доор Ус ба Хүний эрх, Усны эрүүл ахуй, Хог хаягдлаас үүсэх усны бохирдол, Усны үнэ цэнэ сэдвээр сургалтыг зохион байгуулж, сурагчдын дунд мэдлэг бататгах асуулт, хариулт явуулж, идэвхтэй оролцсон сурагчдыг урамшуулсан.<br>• “Орчны эрүүл мэнд” 2026-2028 оны арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд салбарын оролцоо сэдэвт Дархан сумын ЗДТГ, Байгаль орчин газар, Боловсролын газар, Стандарт хэмжилзүйн хэлтэс, Эрүүл мэндийн газар хэрэгжилтийг хангах мэргэжлийн | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгууллагуудын хамтарсан хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Аймгийн хэмжээнд орчны эрүүл мэндийн аюулгүй байдлын сөрөг мэдээллийг бууруулах, сэргийлэх, хяналтын чиглэлээр хэлэлцэж, төлөвлөгөнд тусгасан.<br>• Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/479 дүгээр тушаалаар батлагдсан “Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл явуулах журам”-ын дагуу 3-15кВт хүртэл хүчин чадалтай ердийн галлагаатай зуухыг аймгийн Эрүүл мэндийн газар, Байгаль орчны газар, УЦУОШТ, Стандарт хэмжилзүйн хэлтэс, хамтарсан ажлын хэсгээр 15-100, 100-4200кВт хүчин чадалтай уурын болон усан халаалтын зуухны тоо, бүртгэлийг Дархан, Орхон, Хонгор, Шарын гол сумдын аж ахуй нэгж байгууллагуудад газар дээр хийж гүйцэтгэсэн. Тооллогын дүнгээр<br>- 3-15кВт хүртэл хүчин чадалтай зуух 7557 тоологдож өмнөх оны дүнгээс 378 зуухаар буурсан<br>- 15-100кВт хүртэл хүчин чадалтай 30 зуух тоологдож, өмнөх оны дүнгээс 3-аар буурч 482.95 тн нүүрс хэрэглэсэн<br>- 100-4200кВт хүртэл хүчин чадалтай 12 ААНБ-ын 19 зуухны 17 яндан тоологдож 10184.8 тн нүүрс хэрэглэсэн байна. Өмнөх оны тооллогын дүнтэй харьцуулахад 3 зуухаар буурсан.<br>4200кВт-аас дээш хүчин чадалтай 2 ААНБ 606086 тн нүүрс хэрэглэсэн нь өмнөх оноос 9684 тн-оор илүү хэрэглэсэн байна. | |
| 1.1.8 | Ахмад насны эрүүл мэндийг дэмжих сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах | - | Зохион байгуулсан арга хэмжээ, хамрагдсан ахмадын тоо | 3500 | 2500 | • Эрүүл мэндийн газар, Ахмад хөгжлийн төвтэй хамтран ажиллах гэрээний дагуу долоо хоног бүрийн Лхагва гаригт ахмадын эрүүл мэндийг дэмжих Цусны даралт ихсэлт, Зүрх судасны өвчлөлөөс сэргийлэх, ахмад насны хооллолт, дасгал хөдөлгөөн, сэтгэцийн эрүүл | 80% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэндийн онцлог зэрэг сэдвүүдээр сургалтын хуваарийн дагуу тогтмол зохион байгуулж, тус төвөөр үйлчлүүлэгч 11 удаа 379 ахмад настнуудыг хамрагдсан байна.<br>• Үйлдвэр аж ахуй нэгж, албан байгууллагуудын Ахмадын эрүүл мэндийг дэмжие сэдэвт “Ажлын байрны сургалт”-д 861 ахмад настан хамрагдсан.<br>• Монгол улсын Ерөнхийлөгчийн 53 дугаар зарлиг “Эрүүл монгол хүн” үндэсний хөдөлгөөн, Дархан-Уул аймгийн Засаг даргын 2024-2028 оны мөрийн хөтөлбөр, Дархан сумын Ахмадын хороо байгуулагдсаны 30 жилийн ойг угтсан “Шугаман бүжиг”-ийн аварга шалгаруулах тэмцээнд нийт 9 багийн 120 ахмадууд амжилттай оролцсон.<br>• Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг хамтран ахмад настны эрүүл идэвхтэй насжилтыг дэмжих спорт урлаг, хөдөлгөөний ач холбогдлыг сурталчилан таниулах зорилготой Эрүүл мэндийн салбарын “Түмэн наст оршихуй” ТББ-ын тэргүүлэгч, гишүүдийн оролцоотой “Дасгал хөдөлгөөнд цаг гаргая-алхалт” зохион байгуулж 63 ахмад оролцсон.<br>• “Энэрлээр нэгдэж эвээр бүтээе” энх тавны Хамтдаа алхаж-Энэрэл түгээж- Эв нэгдлийг бэхжүүлье алхалтын үйл ажиллагаа зохион байгуулж, 6км алхалтад 1-18 багийн 172 ахмад оролцсон.<br>• Ахмад настны эрүүл мэнд сургалтад Нэгдсэн эмнэлгийн уламжлалын тасагт хэвтэн эмчлүүлэгч 126 ахмадуудыг хамруулсан.<br>Анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд “Настаны эрүүл мэнд” өдөрлөг үйл ажиллагаанд 863 ахмадууд хамрагдсан байна. | |
| 1.1.9 | Сүрьеэгийн өвчлөлийг бууруулах олон нийтээр удирдуулсан хяналтын салбар зөвлөлийн үйл | УТХО | Уулзалт хэлэлцүүлэг | 2 удаа | 2 удаа | • Сар бүр Олон нийтээр удирдуулсан хяналтын тогтолцооны Дархан-Уул аймгийн салбар зөвлөл хуралдан судалгааны үр дүн болон сүрьеэгийн өвчлөлд үнэлгээ хийн ажиллаж, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллагааг хэрэгжүүлж, сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулна. | | зохион байгуулах | | | Эрүүл мэндийн газрын даргад улирал тутамд зөвлөмж хүргүүлэн ажилладаг. Дархан-Уул аймгийн салбар зөвлөл 2026 онд 3 чиглэлээр 14 үйл ажиллагаа төлөвлөж, хэрэгжилт 70%-тай байна.<br>• ОНУХТ-ны төв зөвлөлөөс бусад 4 салбар зөвлөлдөө 2025 онд хийсэн ажил 2026 онд хийх үйл ажиллагааны чиглэлийг танилцуулан хэлэлцүүлэх уулзалтыг зохион байгуулж салбар тус бүрээс 7 хүн очиж оролцсон.<br>• Дархан-Уул аймагт 5 хүний бүрэлдэхүүнтэй баг ирж Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудыг 26 эмч мэргэжилтнүүдэд судалгаа хийх, дашборт дээр судалгааны үр дүнг хэрхэн оруулах, дүгнэлт хийх арга аргачлалаар сургалт хэлэлцүүлэг зохион байгуулсан.<br>• Сургуулийн өмнөх болон Ерөнхий боловсрол, Коллеж, их дээд сургуулиудын 18 эмч мэргэжилтнүүдэд ОНУХТ-ы талаарх ойлголт, сүрьеэ өвчний талаарх, цаашид хэрхэн хамтран ажиллах талаар сургалт зохион байгуулсан.<br>“Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдөр”-өөр Жаргалтай амьдрал төв, Политехникийн коллеж, Зэвсэгт хүчин 330-р анги, Гэр бүл хүүхэд хамгааллын газар, Татварын газар, Дархан төмөрлөгийн үйлдвэрийн төмөртөй уурхай, Хонгор суман дахь Төмөр толгой уурхай, Дархан Хот тохижилт үйлчилгээний газар зэрэг ажлын байоны сургалтыг 10 удаа 1024 хүнд сургалт зохион байгуулж, Эрүүл мэндийн байгууллагууд “Сүрьэетэй тамцэх дэлхийн өдөр” өдөрлөг зохион байгуулж, 4800 хүн хамруулсан байна. Сүрьеэгийн талаарх реел тэмцээнийг зохион байгуулж 2 хүүхдийг шалгаруулан урамшуулсан | |

| 1.2.Зорилтот бүлгийн хүн амын дунд халдварт болон халдварт бус өвчний эрсдлийн тандалт, судалгаа хийж, сургуульд суурилсан урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгт хамруулах үйл ажиллагааг зохион байгуулах | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2.1 | Өсвөр насны хүүхдийн стрессийн тархалтыг үнэлэх судалгаа хийж, сэтгэцийн эрүүл мэндийн хамгаалах эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллана. | ОНХО | -Сургалтад хамрагдсан хүний тоо, хувь<br>-Стрессийн тархалтын үнэлгээний дүн | -Сургалтад хамрагдсан ЕБС 62.9%, хүний тоо-36.8% | -ЕБС 80%, хүний тоо-50%<br>-Стрессийн тархалтын үнэлгээ ний дүн | • Эрүүл мэндийн газраас Боловсролын газартай хамтран Ерөнхий боловсролын 15 сургуулийн эмч нарт " Өсвөр насны хүүхдийн сэтгэцийн эрүүл мэнд Электрон тамхи түүний хор уршиг, амтны цаана нуугдах үнэн" сэдэвт эрүүл мэндийн боловсрол олгох чадавхижуулах сургалтыг зохион байгуулсан. Сургалтад хамрагдсан эмч нар сургууль тус бүрдээ дунд болон ахлах ангийн нийт 25 бүлгийн 842 сурагчдад сургалт нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулан ажилласан.<br>• Эрүүл мэндийн газрын дэргэдэх “Өсвөрийн эмч клуб”-ын 78 сургагч багш нар Тамхигүй Дэлхийн өдрийг угтан "Сургууль тамхигүй орчин-Тамхигүй ирээдүйг бүтээе" аяны хүрээнд үе тэнгийнхээ 1340 сурагчдад сургалт зохион байгуулсан.<br>Дархан-Уул аймгийн Ерөнхий боловсролын сургууль, коллежийн өсвөр насны 17 настай эрэгтэй суралцагчдыг урьдчилан сэргийлэх үзлэгийн хүрээнд хамрагдсан эрэгтэй суралцагчдын дунд “Өсвөр насны сурагчдын тамхины хэрэглээний тандалт” сэдэвт судалгааны ажлыг хийж, хэрэгжүүлэн үр дүнг нэгтгэн боловсруулсан. Судалгаанд 17 настай 667 сурагчдын 40.1% (n=267) нь ямар нэгэн байдлаар тамхины хэрэглээтэй байсан бөгөөд тэдний дийлэнх нь 13–16 насандаа тамхи хэрэглэж эхэлсэн байна. Мөн тамхи хэрэглэдэг сурагчдын ихэнх нь тогтмол бус болон тогтмол хэрэглэдэг нь өсвөр насанд тамхины хэрэглээ өргөн тархаж, дадал болж байгааг харуулж байна. Тамхи хэрэглэдэг сурагчдын дунд электрон тамхины | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэрэглээ хамгийн өндөр буюу 62.2% (n=155)-ийг эзэлж байсан бөгөөд хэрэглээний гол шалтгаан нь сонирхол, стресс тайлах, найз нөхдийн нөлөөлөлтэй холбоотой байв. Үүнээс харахад үе тэнгийн нөлөө болон сэтгэлзүйн хүчин зүйлс өсвөр насныхны тамхины хэрэглээнд чухал нөлөө үзүүлж байна. Судалгаанд оролцсон сурагчдын ихэнх буюу 55.8% (n=139) нь тамхины хор нөлөөг мэддэг гэж хариулсан хэдий ч хэрэглээ үргэлжилсээр байгаа нь мэдлэг дангаараа зан үйлийг өөрчлөхөд хангалтгүй байгааг харуулж байна. Гэсэн хэдий ч тамхи хэрэглэдэг сурагчдын 54.5% (n=136) нь тамхинаас гарах хүсэлтэй гэж хариулсан бөгөөд найз нөхөд, гэр бүлийн дэмжлэг, эмчийн зөвлөгөө нь тамхинаас татгалзахад хамгийн үр дүнтэй нөлөө үзүүлэх хүчин зүйл гэж үзсэн. | |
| 1.2.2 | Сургуульд суурилсан хүүхдийн биеийн ерөнхий үзлэг, өсөлт хөгжлийн үнэлгээ, амны хөндий үзлэг, нүдний үзлэг, эрсдэлийн үнэлгээний дата бааз үүсгэх, хянах, мэдээллэх, сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна. | - | Улсын дундаж түвшин 5% | Аймгийн үзүүлэлт 5% | 10% | • Гүүднэйборс ОУБ-н Дархан-Уул аймаг дахь салбар Мангирт ОНХХ-н Хүүхэд ивээн тэтгэх хөтөлбөрт бүртгэлтэй 2-18 насны 1865 (96.8%) хүүхдийг 6-өдрийн турш эмч, сувилагч нарын хамтарсан 2 үзлэгийн баг урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгт хамруулсан. Явуулын үзлэгт эхний ээлжинд 1755 хүүхэд хамрагдаж, Анхан шатанд суурилсан илрүүлэг үзлэгт 100 хүүхэд, Онош тодруулах Дүрс оношилгооны үзлэгт 10 хүүхэд (Бамбайн ЭХО - 6, Зүрхний ЭХО - 4) тус тус хамрагдсан.<br>• Эрүүл мэндийн газраас сургуульд суурилсан хүүхдийн биеийн ерөнхий үзлэг, өсөлт хөгжлийн үнэлгээ, амны хөндий, нүдний үзлэг, эрсдэлийн үнэлгээний дата бааз үүсгэх зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн эмч, нарт “Сургуулийн орчинд тулгамддаг эрүүл мэндийн асуудлыг таньж илрүүлэх, анхан шатны тусламж | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үзүүлэх, урьдчилан сэргийлэх чадамжийг нэмэгдүүлэх” сэдэвт чадавхижуулах сургалтыг 2026.02.25-26-ны өдрүүдэд зохион байгуулж сургалтад 23 сургуулийн эмч нарыг хамруулсан.<br>• Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Эрүүл мэндийн төвөөс 2-р сургуулийн эмчтэй хамтран хүүхдийн эмч, мэс заслын эмчийн урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулж, үзлэгт Ерөнхий боловсролын 2-р сургуулийн 1-12 дугаар ангийн 1333 сурагчдаас 1220 сурагч буюу 91.5%-г хамрагдсан. Үзлэгээр Аутизм - 1, Уналт таталт - 1, Хэт хөдөлгөөнтөх эмгэг – 1, Арьс харшлын эмгэг – 7, Гүйлсэн булчирхайн эмгэг - 12, ХБЗ-н эмгэг - 2 , БШЗ-н эмгэг - 2, Зүрх судасны эмгэг - 2, Нүдний хараа муудах эмгэг - 7 тохиолдол буюу нийт 35 (2.8%) тохиолдол бүртгэгдсэн.<br>• Дархан-Уул аймгийн Шарын-Гол сумын Еөрхнхий боловсролын 2 дугаар сургуулийн 1-12р ангийн 1333 сурагчдаас 1220 сурагч буюу 91.5%-г сургуулийн эмч, Шарын-Гол СЭМТ-н хүүхдийн эмч, мэс заслын эмч хамтран сургуульд суурилсан урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, 1220 хүүхдийн үзлэгийн дата баазыг үүсгэж ажилласан.<br><br>ЭХЭМҮТ-н Тандалт үнэлгээний цахим программд аймгийн хэмжээнд сургуульд суурилсан эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан 1547 үзлэгийн үр дүнг шивж, тандалтын бүртгэлийг хийсэн. Үзлэгийн 982 хүүхэд эрэгтэй, 565 хүүхэд эмэгтэй байсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2.3 | Хорт хавдраас сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг орон нутагт хангаж ажиллана. | - | Хэрэгжилтийн хувь | 88.3 | 90.0 | • 2026 оны эхний 5 сарын байдлаар B,C вирусын шинжилгээнд 8255 хүн хамрагдсан. Үүнээс B вирусийн илрүүлэг шинжилгээнд 5288 иргэн хамрагдсанаас B вирусийн ачаалал тоолох шинжилгээнд 159 иргэн илгээж идэвхжилтэй 111 идэвхгүй 5129 байна. Эмчилгээний үр дүн 80 % -тай байна. C вирусын илрүүлэх шинжилгээнд 9066 хүн хамрагдаж Үүнээс 254 хүн эерэг гарч ачаалал тоолох шинжилгээнд 96 хамрагдаж C вирусийн эсрэг эмчилгээнд 72 хамрагдаж, эмчилгээний үр дүн гарсан байна. Эмчилгээний үр 91.6%-тай байна.<br>• 2026 оны эхний 5 сарын байдлаар: Хорт хавдрын шинэ тохиолдлын тоо-97. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 26 тохиолдлоор буурсан.Хорт хавдрын улмаас нас барсан тохиолдлын тоо 79. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6 тохиолдлоор буурсан.Хорт хавдрын шинэ тохиолдол 30.9% эрт үедээ, 69.1% хожуу үедээ оношлогдсон.Одоо 1375 иргэн хавдрын хяналтанд байна.Хөдөлмөр зохицуулалт хийгдсэн хүний тоо-92. Нийт хөнгөвчлөх тусламж үйлчилгээнд хамрагдсан хүний тоо–503. Хөнгөвчлөх тасаг 8 ортойгоор 280 хүнд хөнгөвчлөх эмчилгээ, тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.<br>• Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгт 30-60 насны нийт 7448 эмэгтэй хамрагдахаас 2611 буюу 35.0% -ийн хамрагдалтай. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.4 хувиар өссөн байна. Хавдрын урьдал илэрсэн 87, байран өмөн илэрсэн 0. үрэвслийн эсрэг эмчилгээ 55 хүнд хийгдсэн байна. Эрт илрүүлгээр хорт хавдар оношлогдсон-0.<br>• Хөхний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгт 20-оос дээш насны 21404 эмэгтэй хамрагдахаас 15155 буюу 70.8%-ийн хамрагдалтай. Өмнөх оны | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мөн үетэй харьцуулахад 7.7 хувиар буурсан байна. Эмнэл зүйн үзлэгээр эерэг өөрчлөлттэй гарсан 1. 13А маягтаар 2-р шатлалд илгээсэн 1. Эмчилгээнд-1, эрт илрүүлгээр оношлогдсон хавдар-0.<br>• Хорт хавдраас урьдчилан сэргийлье сэдвээр Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ 45 ажилтан, Ерөнхий боловсролийн 16,18, Монгол-Оюу сургуулийн 203 сурагчдад сургалт зохион байгуулсан.<br>“Наран Ижии Заяа” ТББ-тай эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Хавдар өвчний даван туулагч нарт болон 100 иргэнд сургалт сургалт зохион байгуулсан. | |
| 1.2.4 | Өсвөр насны 17,18 настай эрэгтэй сурагчдын эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулна. | УТХО | Үзлэгт хамрагдсан эрэгтэй суралцагч (%) | 65% | 70% | Дархан-Уул аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн санаачилгаар “Монгол эр хүн” зорилтот төслийн хүрээнд Эрүүл мэндийн газраас хоёрдох жилдээ Дархан-Уул аймгийн хэмжээн дэх ерөнхий боловсролын сургууль, коллежийн өсвөр насны 17 настай эрэгтэй суралцагчдыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж ажиллаа. Өсвөр насны залуусыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, эрүүл мэндийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх сургалтад тогтмол хамруулдаг ч 2025 оны 17 настай эрэгтэй сурагчдын урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан 936 суралцагчдын дунд 1) сэтгэц, зан төрхийн эмгэг, 2) шүдний өвчлөл, 3) хүүхдийн өсөлт хөгжлийн z онооны үнэлгээгээр жингийн илүүдэлтэй хүүхдүүд давамгай байсан. “Монгол эр хүн” зорилтот төсөл, Дархан-Уул аймгийн ЕБС, Политехникийн коллежийн 17 настай эрэгтэй суралцагчидыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахад нийт | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | орвол зохих 1238 хүүхдээс 1019 хүүхдүүдийг хамруулж, хамрагдалтын хувь 82.3% байна. Үзлэгээр: Сэтгэц зан төрхийн өөрчлөлт 336 (33%) Үүнээс зуршилт эмгэг 252 (75%) оношлогдсон. /Энэ эмгэг нь дахин давтагдах зохисгүй үйлдэл хийх эмгэг. Суурь шалтгаан нь тамхины хэрэглээ, дэлгэцийн донтолт, нойрны хямрал зэрэг/. Хэвлийн ЭХО-д илэрсэн хоол боловсруулах замын эмгэг өөрчлөлт 130 (13%). Өсвөр насны эрэгтэй сурагчдын дунд Холецистит 46 (35.3%), Элэгний өөхлөлт 24 (18.5%). Шүд, амны хөндийн өвчлөл: 291 (28.5%). 1-5 хүртлэх шүдний цооролтой хүүхдүүд давамгай байна | |
| 1.2.5 | Эрэгтэйчүүдийн дундах халдварт бус өвчлөлийг бууруулах чиглэлээр захын цусанд сахар, холестрин, B, C вирус илрүүлэх үзлэг хийх, архи, тамхи, хоол, хөдөлгөөн, амиа хорлолт, стрессээс сэргийлэх бүлгийн сургалт зохион байгуулж ажиллана. | - | Скрининг үзлэгт хамрагдсан%<br><br>Тамхинаас гарсан эрэгтэй (%)<br><br>Хөдөлгөөний идэвхтэй эрэгтэй (%)<br><br>Илүүдэл жинтэй эрэгтэй(%) | Скрининг хамрагдсан эрэгтэй 38%<br><br>Тамхи татдаг эрэгтэйчүүд 46%<br><br>Хөдөлгөөний идэвхтэй эрэгтэй 41%<br><br>Илүүдэл жинтэй | 30+ эрэгтэйчүүд хамрагдалт >40<br><br>Архи, тамхи татдаг хэрэглээг 5% бууруулах<br><br>Хөдөлгөөний идэвхийг 5-10% нэмэгдүүлэх | • Эрүүл мэндийн сайдын 2025.11.18-ны өдрийн А/424 дугаар тушаалаар Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд арга хэмжээний 2026 оны төлөвлөгөөг 4 зорилт 33 арга хэмжээг хэрэгжүүлж, хэрэгжилт 40 хувьтай байна.<br>• Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжие “Ажлын байрны сургалт”-ыг Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК, Цагдаагийн газар, ШШГГ-445-р анги, Онцгой байдлын газар, Хот тохижилт үйлчилгээний газар, 330-р Цэргийн анги, Төмөрлөгийн төмөртэй уурхай, Стандарт хэмжил зүйн газар, Дархан Дулааны сүлжээ ТӨХК, Дархан Дулааны цахилгаан станц ТӨХК зэрэг 10 байгууллагын 482 эрэгтэй албан хаагчдыг хамруулсан зохион байгуулсан.<br>• Халамж, үйлчилгээний дэргэдэх “Жаргалтай амьдрал төв” нь архины хамаарал бүхий 62 хүнд 21 хоногийн хугацаанд эмийн эмчилгээ, сэтгэл заслын Минесота загвараар эмчилгээ үйлчилгээг үзүүлсэн байна.<br>Нэгдсэн эмнэлгийн Урологийн тусламж үйлчилгээнд 2026 оны эхний хагас жилд 892 хүн | 30% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | эрэгтэй 34% | | хамрагдсан. Андрологи урологийн хагалгаанд 78 орсон. Үүнээс түрүү булчирхайн томрол- 20 хүн, стент тавих-16 хүн, давсаг дурандах-17 хүн, чулуу бутлах-3 хүн, чулуу авах-1 хүн, стент авах-1 хүн, давсагны хавдар-1 хүн, давсагны чулуу-3 хүн, Шээлэйн чулуу-15 хүн, Бөөрний уйланхай-1 хүн эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна. | |
| 1.2.6 | Улирлын томуугийн цар тахлын хүндрэлийн үнэлгээгээр томуугийн тандалт хийж, үе шатанд тохирсон хариу арга хэмжээ зохион байгуулна. | - | Долоо хоног бүрийн тандалтын мэдээний тоо | 52 долоо хоног | 52 долоо хоног | • Томуу, томуу төст өвчний тандалтыг УТЦТХҮ-ний дагуу 7 хоног бүрээр хийж ХӨСҮТ-д мэдээлж, эргэн мэдээллээр нэгжүүдийг хангаж байна.<br>• 2026 оны эхний 22 долоо хоногийн байдлаар Улирлын томуугийн цартахлын хүндрэлийн үнэлгээгээр АЛАГ ЦООГ ДЭГДЭЛТИЙН ТҮВШИНД- 5 долоо хоног, ИДЭВХЖЛИЙН ТҮВШИНД - 17 долоо хоног үнэлэгдсэн байна. Долоо хоног бүрээр томуугийн тандалтыг хийж эргэн мэдээлэл, томуугийн үнэлгээний түвшинд тохирсон цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны зөвлөмжийг нэгжүүдэд хүргэн ажилласан.<br>2026 оны 3-р сарын 09-15-ны өдрүүд буюу 11-р долоо хоногт ТТӨ-ий оргил үе /10.000 хүн амд 141.1 промил/, АЗЦХХ-ын хамгийн оргил үе 3-р сарын 02-08-ны өдрүүд буюу 10-р долоо хоногт /10.000 хүн амд 8.3 промил/ байсан байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2.7 | Товлолт болон сайн дурын дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлнэ. | - | Хамралтын хувь | 93.5% | 95% | • Дархлаажуулалтын тасралтгүй байдлыг хангах ажлын хүрээнд ХӨСҮТөвөөс 1 удаагийн вакцины татан авалт хийж нэгдсэн эмнэлэг, 5 Өрх, 3 Сумын эрүүл мэндийн төвүүдийг шаардлагатай вакцинаар хангаж ажилласан байна.<br>**Товлолын дархлаажуулалтад:**<br>• Сүрьеэгийн эсрэг сэргийлэх тарилга (БЦЖ) хамрагдвал зохих 672, хамрагдсан 672 буюу 100%<br>• В вируст гепатитийн эсрэг сэргийлэх тарилга хамрагдвал зохих 672, хамрагдсан 672 буюу 100%<br>• Халдварт саагийн идэвхигүйжүүлсэн тарьдаг тарилга хамрагдвал зохих 698, хамрагдсан 695 буюу 99.6%<br>• Халдварт саагийн идэвхигүй уудаг тарилга хамрагдвал зохих 2120, хамрагдсан 2102 буюу 99.2%<br>• Таван (Сахуу, хөхүүл ханиад, татран, В вирусt хепатит, хемофилюс инфлюенза В) вакцинд хамрагдвал зохих 2120, хамрагдсан 2102 буюу 99.2%<br>• Улаанбурхан, гахай хавдар, улаануудын эсрэг сэргийлэх тарилгад хамрагдвал зохих 1307, хамрагдсан 1303 буюу 99.7%<br>• А вируст гепатитийн эсрэг сэргийлэх тарилгад хамрагдвал зохих 1234, хамрагдсан 1225 буюу 99.2%<br>• Пневмококкийн эсрэг сэргийлэх тарилгад хамрагдвал зохих 2095, хамрагдсан 2075 буюу 99%<br>• HPV-хүний папилома вирусын эсрэг сэргийлэх тарилга хамрагдвал зохих 2459, хамрагдсан 1848 буюу 75.15%<br>Үр дүн: Нийт товлолын дархлаажуулалтын хамрагдвал зохих 13377 хамрагдсан 12694 буюу | 94.2% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 95% хамрагдсан байна. Дархлаажуулалтын дараах урвал хүндрэл бүртгэгдээгүй.<br><br>• В вирусын халдвартай 8 эх төрсөн ба В вирусын эсрэг иммуноглобулинд 8 нярай хамрагдсан.<br>• В гепатитийн эсрэг сайн дурын дархлаажуулалтад 546 иргэн хамрагдсан байна.<br>• Балнад өвчнөөс сэргийлэх тарилга ус сувгийн 59 ажилчид хамрагдсан.<br>• Улаанбурхан Улаануud өвчнөөс сэргийлэх нэмэлт болон голомтын дархлаажуулалтад 6114 иргэн хамрагдсан.<br>Хачигт энцефалит өвчнөөс сэргийлэх тарилгад онцгой байдлын 154 албан хаагч хамрагдсан. | |
| 1.2.8 | Эрсдэлт болон зорилтот бүлэг (ЭБЭ, ЭБҮ, мансууруулах бодис хэрэглэгчид, хөдөлгөөнт хүн ам. хоригдол)-т чиглэсэн БЗДХ-ийн халдвараас сэргийлэх сургалт, ухуулга, нөлөөллийн арга хэмжээ болон илрүүлэг үзлэгийг зохион байгуулж, эмчлэн эрүүжүүлнэ. | УТХО | Хамрагдсан хүний тоо | 7000 | 4000 | • 2026 оны хагас жилийн байдлаар Зонхилон тохиолдох өвчин нийт-99 шинэ тохиолдол бүртгэгдсэн. Үүнээс Тэмбүү-59, Трихоманиаз-11, Заг хүйтэн-29 тус тус байна. БЗДХ-ын 2026 оны шинэ тохиолдол 75 бүртгэгдсэн нь өмнөх 2025 оны мөн үетэй харьцуулахад Тэмбүү-21 тохиолдолоор их 64%-иар нэмэгдсэн. Трихоманиаз-11/11 тохиолдлын тоо ижил, Заг хүйтэн-11 тохиолдлоор бага 27.5%-иар буурсан байна.<br>• БЗДХ-ын өвчлөлийн шинэ 99 тохиолдолыг илрүүлэн 98% эмчлэн хяналтанд авсан. Үр дүн: Стандарт эмчилгээг хийж 98% хийж /хавьтал судлал 84% тай/ хяналтанд авсан<br>• Дархан-Уул аймагт:1.Outreach workers "Perfect Ladies" 2."Эрчүүдийн итгэл төгс төв холбоо" 2 Төрийн бус байгууллага нь ЭМГ, НЭ, Өрх, сумын эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажилладаг. Эрэгтэйчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүд (ЭБЭ) – 16 хүн, Эмэгтэй биеэ үнэлэгч (ЭБҮ) – 93 хүн шинжилгээнд | 80% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хамруулж илэрсэн шинэ өвчлөл-4 эмчилгээнд хамруулан хяналтанд авсан. Нууцлал: Судалгаа шинжилгээ нь 100% нууцын зэрэглэлтэй явагдсан.<br>• ХДХВ/ДОХ/БЗДХ-аас урьдчилан сэргийлэх сургалтыг 3479 хүнд зохион байгуулсан. Эрүүл мэндийн газар, МГБССН Монголын гэр бүл сайн сайхны нийгэмлэг, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран ганцаарчилсан болон бүлгийн хэлбэрээр нийт 2000 оюутан залуусыг 14 удаагийн БЗДХ,ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх сэдвээр сургалтанд хамруулан мэдлэг хандлагыг үнэлэхэд 35%-иар нэмэгдсэн байна<br>• ХДХВ/ДОХ-ын халдвартай кодтой/**/иргэний 100%/ хувь нууцлалтай хяналтанд эмчлэгдэж байна. Үүнээс: Хөдөлмөрийн чадвар алдалтыг 9 иргэн тогтоолгосон.Сэтгэл засал эмчилгээнд 5 хяналтын иргэнийг сэтгэл засалч эмчээр зөвөлгөө зөвлөмжинд хамруулсан. ХДХВ Ретровирүсийн эсрэг эмчилгээ, дагалдах халдварын эсрэг, дархлаа дэмжих, өртөлтийн өмнөх болон дараах сэргийлэлтийн эм,тариа, урвалж, оношлуур, эм бэлдмэлийг нэгдсэн байдлаар ХӨСҮТ-өөс ханган нийлүүлж нууцлал болон эрсдэлийн зэргийг тооцон ажиллаж байна.<br>• Эрсдэлт бүлэгт чиглэсэн БЗДХ, ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээллийг нотолгоонд суурилсан, шинэлэг хэлбэрээр үр дүнтэй түгээх ажлыг зохион байгуулсан байна. ХӨСҮТ-ийн тандалт судалгааны алба манай аймгийн 2 төрийн бус байгууллагатай хамтран судалгаа шинэ олон нийтийг илрүүлэх судалгааг шинэчлэх ажлыг хийсэн. /Нийт 621 иргэн хамрагдсан/ | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • БЗДХ,ХДХВ/ДОХ-оос сэргийлэх мэдлэг хандлага зан үйл өөрчлөх сургалт, уулзалт, ярилцлагат хамрагдсан эмэгтэй биеэ үнэлэгчийн тоо өмнөх жилтэй харьцуулахад /80 ЭБҮ/10%-иар нэмэгдсэн байна<br>• ЭБЭ олон нийтийн хэрэгцээ, онцлогт тохирсон ХДХВ/БЗДХ-аас сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд /15 ЭБЭ/ хүрч очих ажилтан тусламж үйлчилгээ үзүүлж хэрэгжүүлсэн байна<br><br>Эрсдэлт бүлэгт ээлтэй тусламж үйлчилгээний кабинетыг шинэ Дархан 15 багт шинээр нээн ажиллуулж эхэлсэн. | |
| 1.2.9 | Зорилтот болон эрсдэлт бүлгийн хүн амыг сүрьеэгийн эрт илрүүлэг үзлэгт хамруулж, сургалт, нөлөөлийн үйл ажиллагаа зохион байгуулна. | УТХО | Зорилтот бүлгийн хүн амын хамрагдалтын хувь | 54% | 65% | • Дархан-Уул аймгийн хэмжээнд сүрьеэгийн эрт илрүүлэг үзлэгт орох зорилтот болон эрсдэлт бүлгийн 5862 хүн амыг хамруулахаар судалгаа гаргасан. Эхний хагас жилийн байдлаар 3892 хүн хамрагдаж үзлэгийн хамрагдалт 66.3%-тай байна. Үзлэгээр 2 сүрьеэг илрүүлэн эмчилгээ хяналтанд авч, тэдний гэр бүл асран хамгаалагчдад сургалт хийсэн.<br>• 2026 оны эхний улирлын байдлаар 37 сүрьеэ бүртгэгдсэн. Үүнд Эмэнд мэдрэг бүрьеэ-21, дахилтат сүрьеэ-16, тэсвэртэй сүрьеэ-6 байна. 2025 онотой харьцуулахад шинэ-8 тохиолдлоор буурсан боловч дахилтат сүрьеэ-6, эмэнд тэсвэртэй сүрьеэ 6 тохиолдол бүртгэгдсэн.<br><br>Сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлье сэдвээр 10 удаа 1024 хүнд ажлын байрны сургалт зохион байгуулсан. Эрүүл мэндийн байгууллагуудын эмч нарыг чадавхжуулах сургалтыг 6 удаа 352 хүнийг хамруулсан. | 100% |
| 1.2.10 | Анхан шатны тусламж үйлчилгээнд МонПЭН, Халдварт бус өвчин, зүрх | - | Хамрагдсан хүний тоо, хувь | 72% | 50% | МонПЕН санаачлагын хүрээнд MN.CARDIO программд суурилсан халдварт бус өвчин (ХБӨ), зүрх судасны өвчний нэн шаардлагатай тусламж | 83,4% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | судас, чихрийн шижин өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдахад аргазүйгээр хангаж, хяналт тавьж үр дүнг тооцож ажиллана. | | | | | үйлчилгээнд хамрагдах зорилтот 67.660 иргэнээс 28,278 иргэн хамрагдаж, хамрагдалт 41.7 хувьтай байна. Зүрх судасны өвчний эрсдэлийн үнэлгээнд 19-39 насны 27.600 иргэн хамрагдсанаас артерийн гипертензи (АГ)-өөр шинээр 142 хүн оношлогдож, бүгд эмчилгээнд хамрагдсан байна. Мөн 94 хүнийг шинээр хяналтад авсан.Чихрийн шижин хэв шинж 2 өвчний эрт илрүүлэг үзлэгт 35 ба түүнээс дээш насны 24140 хүн хамрагдсанаас 39 хүн шинээр оношлогдож, 38 хүн эмчилгээнд хамрагдсан байна. Мөн 92 хүнийг шинээр хяналтад авсан. Түүнчлэн 460 иргэнд ЭХО болон ЭКГ-ийн үзлэг, оношилгоо хийж,15063 иргэнд эрүүл мэндийг дэмжих 15 модулийн зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан. | |
| ***Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр: 2 зорилт 19 арга хэмжээний хэрэгжилтийн дундаж 86.6%*** | | | | | | | |
| **2.ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР:** | | | | | | | |
| **Зорилт 2.1. Эмнэлгийн анхан болон хоёрдугаар шатлалын эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагаа, стандартын хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг зохион байгуулах** | | | | | | | |
| 2.1.1 | Өрхийн эрүүл мэндийн төвтэй байгуулах гүйцэтгэлийн гэрээний хэрэгжилтийг хангаан гэрийн эргэлт, архаг өвчний хяналтын үзлэгийг чанаржуулж, гүйцэтгэлд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана. | - | Өрхийн гүйцэтгэлийн гэрээний үнэлгээний хувь | 92.2% | 93% | Сумын эрүүл мэндийн төвүүд болон Өрхийн эрүүл мэндийн төвүүд нь Даатгалын ерөнхий газартай 2026 оны 01, 04 дүгээр сaруудад гэрээ байгуулан. Харьяалал харгалзахгүйгээр иргэдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг үзүүлж, тусламж үйлчилгээний хүртээмж, тасралтгүй байдлыг хангаан ажиллаж байна<br><br>ЭМДҮЗ-ийн 2026 оны 01 дүгээр тогтоолын дагуу АШЭМБ-уудын тусламж үйлчилгээний нэр төрөл санхүүжилт шинэчлэн батлагдсантай холбогдуулан цахим сургалтанд 2 удаа 45 эмч мэргэжилтэн хамрагдсан. | 93 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Өрхийн ЭМТ, АЗДТГ, ЭМГ хамтран ажиллах гурвалсан гэрээ байгуулан гэрээний хэрэгжилт 93.1%-тай байна. | |
| 2.1.2 | Сумын эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээний багцын хэрэгжилтэд хяналт тавьж мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана. | - | СЭМТ багцын хэрэгжилийн хувь | 86.0% | 87.0 % | Сумын эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээний багцын хэрэгжилт 86.1% байна. | 86% |
| 2.1.3 | Нэгдсэн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандартын хэрэгжилтийг хангахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллана. | - | НЭ стандартын хэрэгжилтийн хувь | 90.1% | 91% | Нэгдсэн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандартын хэрэгжилт 92% | 92 |
| 2.1.4 | Алслагдсан орон нутгийн хүн амд “Явуулын эрүүл мэндийн тусламж үйлчилгээ” Мобайл техниологийг хүн амд хүргэхэд мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана. | УТХО | Хамрагдсан хүн ам | 1321 | 1000 | Орхон, Хонгор, Шарын гол СЭМТ-үүдтнй хамтран ,дүрс оношилгоо ,дотрын нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг Явуулын тусламж үйлчилгээг 2 удаа зохион байгуулахад нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар ханган давхардсан тоогоор нийт 85 өрхийн 1300 гаруй иргэдийг хамруулсан байна.<br><br>АИТХ,ОБГ,ЭМГ,ХХАГ хамтран зудын эрсдэл тогтоох ,ЭМТҮ хүргэх зорилгоор Нэгдсэн эмнэлэгтэй хамтран малчдад урьдчилан сэргийлэх үзлэгийг 65 өрхийн 128 иргэнд үзүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.5 | Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг ханган, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллана. | УТХО ОНХО | Төлөвлөгөөний тодотгол хэрэгжилтийн хувь | 95% | 95% | Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Гамшгаас хамгаалах төлөвлөгөөМонгол Улсын Шадар сайдын 2023 оны 28 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан холбогдох журам,Онцгой байдлын ерөнхий газар-ын даргын 2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн “Гамшгаас хамгаалах Команд штабын сургууль зохион байгуулах тухай” А/115 дугаар тушаал,Эрүүл мэндийн яам-ны сайдын 2026 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/151 дүгээр тушаалын хүрээнд эрүүл мэндийн салбарын “Гамшгаас хамгаалах команд штабын сургууль”-ийг 2026 оны 05 дугаар сарын 13-15-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа.<br><br>Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн алба 45, мэргэжлийн ангийн 25, Онцгой байдлын газрын 6 нийт 76 албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр оролцож, 4 автомашин техник хэрэгсэлтэйгээр бэлтгэл бэлэн байдлаа ханган **Хангалттай** үнэлгээ авсан байна.. | 100 |
| 2.1.6 | Иргэдийн дунд сайн дурын авлагагүй донорын үйл ажиллагааг идэвхижүүлж, аюулгүй цус, цусан бүтээгдэхүүн бэлдэхэд дэмжиж ажиллана. | - | Цус цусан бүтээгдэхүүн | 820 нэгж цус, сийвэн | Шаардлага тай тохиолдлы н тоогоор | Суурин хэлбэрээр 420 нэгж цус цуглуулсан. ДДЦС ТӨХК-тай хамтран ажиллаж явуулаар 38 донороос 36 нэгж цус цуглуулсан. | 100 |
| **Зорилт 2.2. Эмнэлгийн тусламж үйчилгээнд оношилгоо, эмчилгээний чадавхийг сайжруулах, дэвшилтэт технологийг нутагшуулах үйл ажиллагааг дэмжиж ажиллах** | | | | | | | |
| 2.2.1 | Оношилгоо, эмчилгээний чадавхийг сайжруулах, дэвшилтэт технологийг | УТХО | Нэвтрүүлсэн технологи | Шинэ технологи 4 | Шинэ технологи 1-2 | Үений дурангийн мэс засал, Цээжний хөндийн битүү гэмтэл хавирганы хугарлыг бэхлэх мэс засал зэрэг хагалгааны нэр төрлийг нэмэгдүүлэн шинээр нутагшуулан ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нутагшуулахад дэмжиж ажиллана. | | | | | Монголын мэдээгүйжүүлэгч эмч нарын нийгэмлэг болон Нидерланд улсын Нидерланд улсын Albert Schweitzer эмнэлгийн мэдээгүйжүүлгийн эмч XAVIER FALIERES-тэй хамтран “Захын мэдрэлийн хоригуудыг хэт авиан хяналтанд хийх нь” онол дадлагын ажлын байрны сургалт хийсэн.<br><br>Уламжлалтын тасагт Гуаша эмчилгээг шинээр эмчилгээнд нэвтрүүлж, эмчилгээний төрлийг нэмэгдүүлэн ажиллаж байна. Эмчилгээнд нийт 10 хүн хамрагдсан. | |
| **Зорилт 2.3. Жирэмсэн эмэгтэйчүүд, нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээний чанар үр дүнг сайжруулах** | | | | | | | |
| 2.3.1 | Жирэмсний эрт үеийн хяналт, хамралтыг сайжруулан жирэмсэн үеийн ХДХВ, тэмбүү, гепатитын В, С, вирусийн илрүүлэг шинжилгээний хамрагдалт, тэмбүүтэй жирэмсэн эмэгтэйн эмчилгээ, хяналт, хавьтлын илрүүлэлт, оношилгоо, эмчилгээний байдалд хяналт тавихад мэргэжил арга зүйн дэмжлэгт удирдлагаар ханган ажиллана. | - | Эрт хамралтын хувь | 96.4% | 96.5% | Дархан уул аймгийн жирэмсэн эхний 5 сарын байдлаар 598 эх хяналтанд орсон.Эрт хяналтанд 573 буюу 95.8% байна.<br><br>2025 оны 05 сарын 15 ны өдөр Эх барих, эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах хэлэлцүүлэг, сургалт зохион байгуулж Нэгдсэн эмнэлгийн Поликлиник-2 тасгийн эх барих эмэгтэйчүүдийн эмч, мэргэжилтнүүд болон Амин холбоо, Түвшин холбоо, Гос хот, Медстоб, Гэрэлтэй Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн жирэмсний хяналтын мэргэжилтнүүд хамрагдсан. Амбултори -2 тасгийн дотрын эмч ӨӨЖЭ-ийн эмч нар хамтран Өрх болон сумдын эх баригч эмч хяналтын эмч нарт “Жирэмсний хяналт, чихрийн шижин өвчтнй эхийн хяналт” сэдвээр 24 эмч мэрэгжилтэнд сургалт зохион байгуулав.<br><br>ЭХЭМҮТ-ийн тандалт судалгааны алба,Эх барих эмэгтнйчүүдийн клиникээс зохион байгуулдаг | 95.8 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цахим сургалтанд 6 удаа 250 эмч мэргэжилтэн хамрагдсан. | |
| **Зорилт 2.4. Хүүхэд, нярайд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар үр дүнг сайжруулах** | | | | | | | |
| 2.4.1 | Хүүхэд, нярай ,өсвөр үеийнхний дунд зонхилон тохиолдлох өвчлөл, нас баралтад судалгаа хийж, сэргийлж болох нас баралтыг бууруулах чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр хангаан ажиллана. | - | Судалгааны дүн мэдээ | Судалгаа 1 | Судалгаа 1 | Хүүхэд нярай, өсвөр үеийхнийг дунд зонхилон тохиолдох өвчлөл (амбулаторийн)<br>1. Амьсгалын эрхтэн тогтолцоо-14369<br>2. Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны -4347<br>3. Арьс харшил-2002<br>4. Нүд дайврын эмгэг -1505<br>5. Чих хөхөлцөгийн эрхтэн тогтолцооны эмгэг -1177<br>1-р улирлын хүүхдийн эндэгдлийг магадлан хэлэлцэх хурлыг зохион байгуулж 3 тохиолдолыг авч хэлэлцэж цаашид нярайн эндэгдлийг бууруулах чиглэлээр НЭ-т 3 чиглэлийн зөвлөмж хүргүүлж, ажил сайжруулах төлөвлөгөө гаргуулан ажиллаж байна. Өрх, сумын ЭМТ-үүдэд 2 чиглэлийн зөвлөмж хүргүүлэн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. | 100 |
| 2.4.2 | 9, 18, 36 сартай хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, өвчлөл илэрсэн хүүхдүүдийг эмчлэн эрүүлжүүлэх үйл ажиллагааг мэргэжил арга зүй дэмжлэгт удирдлагаар ханган ажиллана. | - | -Хамрагдсан хүүхдийн тоо | 2541 | 2000 | 9,18,36 сартай хүүхдийн цогц үнэлгээ хийх талаар 5 ӨЭМТ, 3 СЭМТ-д сургалт аргазүйгээр хангаж сар бүрийн 25-наар тасалбар болгон нэгтгэх талаар арга зүйн зөвлөмж өгсөн. 2026 оны эхний 5 сарын байдлаар 9 сартай хамрагдвал зохих 758 хүүхдээс хамрагдсан 716 буюу 94,4%, 18 сартай хамрагдвал зохих 738 хүүхдээс хамрагдсан 676 буюу 91,6%, 36 сартай хамрагдвал зохих 786 хүүхдээс хамрагдсан 735 буюу 93,5% байна. Нийт хамрагдалт 2282 хүүхдээс 2127 буюу 93,2% нь хамрагдсан байна. | 100 |
| 2.4.3 | Шинэчилсэн ХӨЦМ болон олон нийтэд суурилсан ХӨЦМ-ийн сургалт зохион | - | -сургалтад хамрагдсан ЭМА, | Эцэг эх-485<br>ЭМА-73 | 300 эцэг эх<br>ЭМА 50 | ХӨЦМ, Хүүхдийн тусламж сургалтыг АШУҮИС-ийн хүүхдийн тэнхмийн эрхлэгч АУ-ны доктор,профессор Г Эрдэнэтуяа, Хүүхдийн тэнхмийн ахлах багш Анагаах ухааны доктор Э | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгуулахад мэргэжил арга зүйгээр хангаж, ХӨЦМ-ийн тандалт, үнэлгээ хийж ажиллана. | | эцэг эхчүүдийн тоо | | | Хэрлэн нар сургалт дадлагахийсэн. Сургалтанд өрх, сум, НЭ-ийн 53 эмч, мэргэжилтэнгүүд хамрагдсан. ХӨЦМ-ийн тандалтын удирдамжийн дагуу өрх, сумын ЭМТөвд хийж байна. ХӨЦМ-ийн сургалтыг 275 асран хамгаалагчдад хийсэн байна. | |
| 2.4.4 | Нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана. Үүнд:<br>• Ургийн гажгийн эрт илрүүлэг<br>• Нярайн эрт илрүүлэг(түнх, зулайн эхо, сонсгол, нүдний скрининг) | УТХО | Үзлэгт хамрагдсан хүүхэд | Нярайн эрт илрүүлэг 1542 | 678 | Нийт төрсөн нярай-678 хамрагдсан 665 эмчилгээтэй 13 нярай байна. Сонсголын скрининг – 665, Зүрхний гажиг эрт илрүүлэг скрининг - 665 Нүдний скрининг – 665, Зулай ЭХО – 612, Түнхний ЭХО - 665. Нярайн эрт илрүүлэгийн төрлийг нэмэгдүүлэх талаар АШУҮИС-ийн хүүхдийн тэнхмийн эрхлэгч Анагаах ухааны доктор профессор Г Эрдэнэтуяа болон НЭ-ийн дарга Б Мөнхбат ,Нярайн тасгийн эрхлэгч Д Бүрэнжаргал нартай уулзалт ярилцлага хийж гэрээ байгуулан бодисын солилцоо дотоод шүүрлийн эмгэг илрүүлэх скрининг хийгдэж эхэлсэн. | 98 |
| **Зорилт 2.5. Уламжлалт анагаах ухаан хөнгөвчлөх, сэргээн засах, сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах** | | | | | | | |
| 2.5.1 | Уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх арга хэмжээний (2025-2028) төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, мэргэжил аргазүйгээр хангаж ажиллана. | - | -Сургалтад хамрагдсан ажилтны тоо<br>-Тусламж үйлчилгээ авсан иргэдийн тоо | Сургалтад хамрагдсан 9<br>-Тусламж үйлчилгээ авсан иргэд 658 | Сургалтад хамрагдах 10<br>-Тусламж үйлчилгээ шаардлагатай иргэд 670 | Монгол улсын Засгийн газрын 2026 оны 03 сарын 13 ны өдрийн 87 тоот тогтоолоор батлагдсан “Монголын уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх” талаар 2026-2030 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу Уламжлалт анагаах ухааны эмч нарыг чадавхийг дээшлүүлэх зорилгоор “Вирусын шалтгаант элэгний цирроз үрэвслийн үеийн УАУ ны тусламж үйлчилгээ” сэдвээр сургалт зохион байгуулагдсан .<br>Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх тухай” зарлигтай холбогдуулан Монголын Нэгдмэл Анагаах Ухааны Нийгэмлэгээс зохион байгуулсан “ТӨВИЙН БҮС НӨЛӨӨЛӨЛ-2026” сургалт, хэлэлцүүлэгт | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | оролцсон. ЭМЯ –наас зохион байгуулсан Уламжлалт анагаах ухааны өдөрлөгт Хувийн хэвшлийн Эрүүл мэндийн Энх уламжлал, Манби жалбо эмнэлгүүд оролцож иргэдэд уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээ үзүүлж, эрүүл амьдралыг хэвшүүлэх үндсэний хөтөлбөрийг сурталчилан 1500 гаруй иргэдийг хамруулсан байна.<br><br>Уламжлалт анагаах ухааны чиглэлээр тусламж үйлчилгээ авсан иргэд: Амбулаторийн үзлэг 1300, өдрийн эмчилгээнд 100. | |
| 2.5.2 | Хөнгөвчлөх, хими эмчилгээний тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана. | - | -Тусламж үйлчилгээ авсан иргэдийн тоо | - Хэвтэн эмчлүүлсэн 492 үйлчлүүлэгч | - Тусламж үйлчилгээ шаардлагатай иргэд | Хөнгөвчлөх эмчилгээний тасагт нийт 281 үйлчлүүлэгч хэвтсэн. Орны фонд ашиглалт 78,9 буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6% буурсан. Дундаж ор хоног 9,4 байна. Эмчлэгдсэн өвчтөн 281, нас барсан 27 үүнээс хоног болоогүй нас баралт 8.<br><br>Хөнгөвчлөх эмчилгээний сувилахуйн тулсамж үйлчилгээг нийт 2065 хүнд үзүүлсэн. Үүнд:<br>✓ Нийт хатгалт давхардсан тоогоор 15.265 дундаж хатгалт 7.3<br>✓ Сувилагч эмчлүүлэгчийн биеийн байдлийг үнэлэх – 8400<br>✓ Амин үзүүлэлт – 15.820<br>✓ Өвдөлтийг хянах - 1728<br>✓ Шингэний бланс хөтлөх - 149<br>✓ Уян зүү тавьсан - 367<br>✓ Асаргаа хийсэн - 1608<br>✓ Бүтэн биеийн угааллага - 39<br>✓ Хэсэгчилсэн угаалага - 322<br>✓ Шарханд боолт хийсэн - 18<br>✓ Шээлгүүр тавьсан – 17<br>✓ Хүчилтөрөгч өгсөн-230 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ✓ Цэр салст соруулсан-23<br>Үр дүн: Хөнгөвчлөх эмчилгээний сувилахуйн тулсамж үйлчилгээг нийт 2065 хүнд 12 төрлөөр үзүүлсэн байна. | |
| 2.5.3 | Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах сургалт зохион байгуулах, гардан үйлдлийн стандартын хэрэгжилтийг үнэлэхэд мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана . | - | Сургалтад хамрагдсан эмнэлгийн мэргэжилтний тоо, үнэлгээний хувь | Сургалтад хамрагдсан 457 сувилагч<br>- Гардан үйлдлийн стандартын хэрэгжилт 85% | -Сургалтад 460 эмнэлгийн мэргэжилтэн<br>-Гардан үйлдлийн стандартын хэрэгжилт 87% | Эх баригчийг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу ЭХЭМҮТ-ийн сургагч багш нар аймгийн эх баригч 24 ажилтанд Жирэмсний бүлгийн хяналтын сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгуулсан.<br>Эх нярай эмэгтэйчүүдийн үндэсний төвд “Жирэмсний бүлгийн хяналт”-ын сургагч багш нарыг шинэчилсэн хөтөлбөрөөр бэлтгэх сургалтанд 10 эх баригч хамрагдав. ЭХЭМҮТ-д 2 эх баригч 1 сарын хугацаатай мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан байна. Эх,хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, НҮБ-ын Хүн амын сангаас манай дэмжлэгт хяналт хийж, Эхийн болон перинатал эндэгдлийн шалтгаан, нөлөөлж буй хүчин зүйлийг илрүүлж, урьдчилан сэргийлж болох амьгүй төрөлт, нярайн болон эхийн эндэгдлийг бууруулах үйл ажиллагааг эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хяналтын тогтолцоотой уялдуулах нь сургалтыг зохион байгуулсан.<br>**Сувилагч нарыг чадавхижуулах ажлын байрны** сургалтыг 12 сэдвээр 9 удаа зохион байгуулж, 674 сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн хамрагдсан байна. Сувилагчдын гардан үйлдлийн стандартын үнэлгээг IV улиралд хийнэ. Сувилахуйн дагнасан 3 төвийн гардан үйлдлийн стандартын хэрэгжилтэд үнэлгээ хийхэд 85%-тай байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | |
| 2.5.4 | Сэргээн засах тусламж үйлчилгээний эмнэл зүйн зааврын хэрэгжилтийг хангуулж, ХБИ-ийн төвтэй хамтран ажиллахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллана. | - | Сургалтад хамрагдсан ажилтны тоо<br><br>Тусламж үйлчилгээ авсан иргэд | 11<br><br>6208 | 15<br><br>Тусламж үйлчилгээ шаардлагатай иргэд | MNS 4621:2008 Түгээмэл үйлдлийн стандартын дагуу үзүүлж байгаа Сэргээн засах тусламж үйлчилгээний төрөл:<br>1. Цахилгаан эмчилгээ-3313<br>2. Гэрэл эмчилгээ-6147<br>3. Бариа засал эмчилгээ /хэсгийн бариа/ -1210<br>4. Бумба /соруул/ засал эмчилгээ-3300<br>5. Гулгуур бумба /бумбат иллэг-127<br>6. Зөгийн балтай татлага эмчилгээ-97<br>7. Парафин/ эмчилгээ-2245<br>8. Хүзүүний татлага эмчилгээ-173<br>9. Сээр болон бүсэлхий нурууний татлага эмчилгээ-81<br>10. Хөдөлгөөн засал эмчилгээ-1469<br>11. Хүүхдийн хөдөлгөөн засал эмчилгээ-242<br>12. Хөдлөмөр засал/Ахуй заслын/ эмчилгээ-308<br>13. ЭБДасгал эмчилгээ-268<br>14. Зүү эмчилгээ-2007<br>15. Цахилгаан зүү эмчилгээ-226<br>16. Төөнө засал эмчилгээ-112<br>17. Хүчилтөрөгч коктель эмчилгээ-930<br>18. Хүүхдийн багц эмчилгээ-159<br>**Үр дүн:** Шинээр нэмэгдүүлсэн нэр төрөл 1 буюу Хүүхдийн багц эмчилгээ. Сэргээн засах тусламж үйлчилгээг нийт 24 нэр төрлөөр давхардсан тоогоор 22414 үйлчлүүлэгчдэд үзүүлсэн.<br><br>ЭТҮХ-ийн мэрэгжилтэн 7 албан хаагч Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвийн үйл ажиллагаатай танилцан хамтран ажиллах талаар хэлэлцүүлэг зохион байгуулсан. Нэгдсэн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эмнэлэг,өрх сумдын нөхөн сэргээх тусламж үйчлилгээ үзүүлдэг 15 сувилагч нарыг сургалтанд хамруулсан. | |
| **Зорилт 2.6. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулж, үйлчлүүлэгч төвтэй тусламж үйлчилгээг үзүүлэх** | | | | | | | |
| 2.6.1 | Тусламж, үйлчилгээний чанарын тасралтгүй хөгжлийг дэмжсэн магадлан итгэмжлэл бүхий чанарын нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн болон дэмжлэгт удирдлагаар хангаж ажиллана | - | Магадлан итгэмжлэлд хамрагдсан ЭМБ | 9 | 10 | 2026 онд магадлан итгэмжлэх үнэлгээнд хамрагдах 11 эрүүл мэндийн байгууллагаас 1 ЭМБ албан тоотоор өөрийн хүсэлтээр үнэлгээнд хамрагдаагүй, 1 Сумын ЭМТ, 2 ӨЭМТ ЭМС-н 2025 оны А/426 тушаалаар “Магадлан итгэмжлэлийн эрх зүйн эрх зүйн шинэчлэл, тасралтгүй байдлыг хангах зорилгоор” магадлан итгэмжлэлийг 1 жилээр сунгаж, 5 ЭМБ-н 22 шаардлага, 14 материалыг ЭМБ-ын цахим системд мэдээлэл оруулах, илгээх сургалтыг хийж, цахим програмд оруулсан мэдээллийг хянан Эрүүл мэндийн хөгжлийн төвд илгээн баталгаажуулах зэрэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэв. 2026 Магадлан итгэмжлэл үнэлэх шинжээчийн баг 8 гишүүний бүрэлдэхүүнтэй томилогдон ажиллаж 5 ЭМБ-д үнэлгээ хийж Эрүүл мэндийн сайдын 2026 оны 03 сарын 11 –ны өдрийн А/86 дугаар тушаал, 2026 оны 03-р сарын 25-ны А/122 тоот тушаал, тушаалаар 2 эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэл 2 жилийн хугацаагаар сунгагдан ирсэн. Мөн үнэлгээнд хамрагдсан 3 ЭМБ Шинжээчийн багийн нэгдсэн дүгнэлтээр Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/503 тушаалаар батлагдсан Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх журмын 7.3 дах заалтаар магадлан итгэмжлэлийн шалгуурын босго оноог хангаагүй тул зөвлөлийн шийдвэрээр магадлан итгэмжлэл олгохоос татгалзав. Магадлан итгэмжлэх үнэлгээнд хамрагдсан 5 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ЭМБ-ын шинжээчийн зөвлөмжийг ЭМБ-уудад хүргүүлж ЭМС-ын А/112 тушаалын 3-р хавсралтын дагуу “Эрүүл мэндийн байгууллагын, тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө” боловсруулах арга зүйн зөвлөгөө өгч ажилласан | |
| 2.6.2 | Чанарын аян, өдөрлөг зохион байгуулахад удирдлага арга зүйгээр хангаж, зохион байгуулалтад дэмжлэг үзүүлж ажиллана . | - | Зохион байгуулсан үйл ажиллагаа, хамрагдсан иргэд | 2 удаа 2451хүн | 2-3 удаа 1500 хүн | Жил бүрийн 4 дүгээр сарын сүүлийн долоо хоногт Дэлхий даяар "Эрүүл мэндийн лабораторийн мэргэжилтний 7 хоног" -ийг тэмдэглэн өнгөрүүлдэг бөгөөд Нэгдсэн эмнэлгийн Эмнэл зүйн -Эмгэг судлалын лабораторийн тасгаас Эмнэлгээр үйлчлүүлэгч иргэдэд "LAB WEEK- Эрүүл мэндийн лабораторийн мэргэжилтний 7 хоног" нээлттэй өдөрлөгийг зохион байгуулж, Элэгний В, С вирусын илрүүлэг шинжилгээ-38, эрдэсийн шинжилгээ 38 иргэнээс авч, эрүүл мэндийн мэдээлэл өгч ажилласан.<br><br>Дэлхийн өрхийн эмч нарын өдөр Дархан 50 цогцолборт нээлттэй өдөрлөг зохион байгуулж “Дижитал ертөнцөд-Энэрэнгүй тусламж” үйлчилгээ уриан дор үзлэг,ЭХО, ЭКГ, хурдавчилсан оношлуурын шинжилгээ сахар, хеликобактер, холестрин үзлэг хийсэн.<br><br>"НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ", "ХУУЛЬЧИЙН ПРО БОНО-2026" нэгдсэн өдөрлөгийг зохион байгуулахад Эрүүл мэндийн салбарын эмч, мэргэжилтнүүд Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой санал, гомдол хүлээх авах, Эм эмнэлгийн хэрэгслийн хуулийг таниулах, Эмийн зохистой хэрэглээ, ЭМД-ын тухай мэдээлэл зөвлөгөө, мөн анхан шатны тусламж үйлчилгээг иргэдэд үзүүлэн ажилласан. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.6.3 | Эрүүл мэндийн байгууллагуудаар үйлчлүүлэгчид болон эмч ажилтны сэтгэл ханамжийн судалгааг 1313 mn-ээс цахимаар авч үр дүнг тооцож үйл ажиллагаагаар зохион байгуулж ажиллахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлнэ. | - | - Иргэдийн сэтгэл ханамжийн хувь | 82.85 % | 85 % | Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний ил тод байдлыг хангах, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг үнэлэх #цахим порталыг ашиглан 1313 mn сайтад 3988 иргэнээс сэтгэл ханамжийн судалгаа авсан байна. Үүнээс хэвтэн эмчлүүлэх тусламж үйлчилгээ авсан 175 иргэн, амбулаторийн тусламж үйлчилгээ авсан 3813 иргэнээс сэтгэл ханамжийн үнэлгээг цахим хэлбэрээр авсан байна. Хэвтэн эмчлүүлэх тусламж үйлчилгээ авсан иргэдийн нэгдсэн сэтгэл ханамж маш сайн-38.2%, сайн-50%, дунд 9%, муу-2.8% байгаа бол амбулаторийн тусламж үйлчилгээ авсан иргэдийн сэтгэл ханамжийн дундаж хувь маш хангалттай 1360 буюу 35.6%, хангалттай 2213 буюу 58%, дунд зэрэг 233 буюу 6.1%, огт хангалтгүй 7 буюу 0.3% гэсэн сэтгэл ханамжийн үнэлгээ өгсөн байна. | 90 |
| 2.6.4 | Эрсдэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, эрсдэлээс сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллана. | - | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 74% | 50% | ЭМТҮЧАБА-аас 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөт хяналт-үнэлгээг хуваарийн дагуу 11 чиглэлээр хийхээр төлөвлөснөөс 5 чиглэлээр хяналт хийсэн. Үүнд<br>1. Өвчний түүхийн хөтлөлтөд ЭМДҮЗ-ийн 12-р тогтоолын дагуу хяналт<br>2. Ижил мэргэжилтний үзлэгийг НЭ-ийн захирлын 2026 оны А/162 дугаар тушаалын дагуу тасаг бүрээр зохион байгуулсан.<br>3. Үйлчлүүлэгчийн зөв танин тодруулах хяналтыг ЭМС-ын А/352 тоот тушаалын дагуу 13 тасагт хяналт хийхэд МЭЭ-ийн тасаг 100%, эмгэг нярай 75%, дотор, хөнгөвчлөх эмчилгээний тасаг-52,3%, мэдрэлийн тасаг 26,4%, гэмтлийн тасаг 83,3%, мэс заслын /хими, хавдар/ тасаг 62,5% хэрэгжилттэй.<br>4. 04 дүгээр сард 2024 оны ЭМС-ын А/292 дугаар тушаалын хэрэгжилтийн биелэлтийг үнэлэх, | 80 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | жирэмсний хяналтын сайжруулах зорилгоор Поликлиник-II тасгийн “Жаргалтай ээж төв”-д хяналтын хуудас боловсруулан үнэлэн, жирэмсний хяналтанд байгаа эмэгтэйчүүдээс сэтгэл ханамжийн судалгаа авсан. Дэмжлэгт хяналт, үнэлгээгээр ЭМС-ын А/292 дугаар тушаалын хэрэгжилт хэсэгчлэн хангагдсан үнэлгээтэй.<br>5. 04 дүгээр сард ЭМТҮЧАБАлба, Эмзүйн алба хамтран Мансууруулах, сэтгэц нөлөөт эмийн хяналтыг 14 тасагт хийхэд үнэлгээ 77,3%, Өндөр эрсдэлт эмийн хадгалалт, хэрэглээ, зарцуулалтад 13 тасагт хяналт хийхэд үнэлгээ 48.1%<br>ЭМС-ын 2019 оны 12 сарын 12-ны өдрийн А/566 тоот тушаалын хоёрдугаар хавсралтад заасан Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ эрсдэлийг бүртгэх, хариу арга хэмжээ авах ажлын хүрээнд гал тогоо, хими эмчилгээ, хүчилтөрөгчийн бэсрэг үйлдвэр, нярайн тасаг, эмзүйн албаны ТҮ олгох эм тариа гэсэн 5 хэсэгт хяналт хийхэд 100 эрсдэл бүртгэгдсэнээс ноцтой эрсдэл-3, өндөр эсдэл-23, дунд эрсдэл- 37, бага эрсдэл- 37.<br>Эргэн хяналт: Эргэн хяналтаар гүйцэтгэлийн хугацаа, эргэн хяналт тавих хугацааг товлон холбогдох алба, тасаг, хариуцах ажилтан нарт танилцуулан учирч болох аюул эрсдэлээс сэргийлж, бууруулан ажиллах чиглэл, зөвлөмж /хугацаатай/ өгч ажилласан. | |
| 2.6.5 | “Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага” MNS 7014:2023 стандартын үнэлгээ хийж зөвлөмж өгч, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана. | - | Стандартын хэрэгжилтийн хувь | 70% | 75% | MNS-7014:2023, ЭМС-ын А/274, А/537 тоот тушаалын хэрэгжилт:<br>➢ Эмнэлгийн мэргэжилтэний хувцаслалт, биеэ авч явах соёлоор **24** сувилагч ,тусгай мэргэжилтэн хяналт үнэлгээ хийхэд **нийт дундаж үнэлгээ -90,2%.**<br>➢ Гар угаах, халдваргүйжүүлэх мэдлэг дадлыг үнэлэх үнэлгээнд **17** сувилагч | 93.3 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ,тусгай мэргэжилтэн хамрагдсан . **Нийт дундаж үнэлгээ-96,2% .**<br>➢ Өдөр тутмын үйл ажиллагааг үнэлэх үнэлгээнд 7 төрлөөр **41** сувилагч ,тусгай мэргэжилтэн хамрагдсан. **Нийт дундаж үнэлгээ-90% .**<br>➢ Халдваргүйжүүлэх бодис, уусмалын хэрэглээг хянах үнэлгээнд **14** сувилагч ,тусгай мэргэжилтэн хяналт үнэлгээ хийхэд **нийт дундаж үнэлгээ -88,3%.**<br>➢ АШМаягтын хөтлөлт **30** сувилагч ,тусгай мэргэжилтэн хамрагдсан.**Нийт дундаж үнэлгээ-100%**<br>Үнэлгээнд **нийт- 126** сувилагч, тусгай мэргэжилтан хамрагдсан.<br><br>**Нийт дундаж үнэлгээ- 93,3%** | |
| 2.6.6 | Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдварын сэргийлэлт, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг дэмжиж ажиллана. | - | Зохион байгуулсан үйл ажиллагаа | 3 | 4 | .Дархан нэгдсэн эмнэлгийн асрагч нарт эмнэлгийн байгууллагын онцлогт суурилсан баримжаа олгох сургалтыг ЭМБ-д цэвэрлэгээ хийх стандарт болон асгарсан шингэн, органик нэгдэлүүдийг цэвэрлэх, А/537-р тушаалын 3 дугаар хавсралт өртөлтийн дараах сэргийлэлт зэрэг сэдвүүдээр дадлага сургалтыг зохион байгуулсан.<br><br>Халдварын сэргийлэлт хяналтын алба болон Төвлөрсөн ариутгал халдваргүйжүүлэгийн тасгаас хамтран эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэхэд чиглэгдсэн ЭМС-ын тушаал, эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд ашиглагдах багаж материал, хэрэгслийн халдваргүйтгэл, үүсэж байгаа эмнэлгийн тусгай хог хаягдлыг ангилан цуглуулах, түр хадгалах, тээвэрлэх үйл ажиллагааны талаар сувилагч, тусгай | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэргэжилтнүүдийн халдварын сэргийлэлт, хяналтын талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх зорилго бүхий цуврал сургалтыг зохион байгуулсан.<br><br>Нэгдсэн эмнэлгийн Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албанаас тасаг нэгжийн чанарын багийн гишүүдэд чанарын суурь ойлголт олгох, эрсдэл болон тохиолдлыг илрүүлэх, бүртгэх, мэдээллэх, дүн шинжилгээ хийх, сайжруулах, арга хэмжээ авах чадварыг эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулаа. Уг сургалт нь чанарын үндсэн ойлголтыг эзэмшүүлэх, тохиолдол эрсдлийг тодорхойлох, RCA, CAPA хэрэгжүүлэх чадвар олгох, чанарын багийн үүргийг тодорхой болгох талаар мэдээлэл өгч, санал солилцсон. | |
| ***Эмнэлгийн тусламж үйлчилгээний чиглэлээр 6 зорилт 22 арга хэмжээний хэрэгжилт 90.8%*** | | | | | | | |
| **3. ХҮНИЙ НӨӨЦИЙГ ЧАДАВХИЖУУЛАХ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР:** | | | | | | | |
| **Зорилт 3.1. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн сургалт хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах** | | | | | | | |
| 3.1.1 | Үндсэн болон төрөлжсөн чиглэлээр эрүүл мэндийн ажилтнуудыг мэргэжил дээшлүүлэх болон төрөлжсөн мэргэшил эзэмшихэд дэмжлэг үзүүлнэ. | УТХО | бэлтгэсэн мэргэжилтэний тоо | 21 их эмч, 8 сувилагч | 15-20 эмч эмнэлгийн мэргэжилтэн, | Төрийн сангийн сургалтад үндсэн мэргэшил 5, төрөлжсөн мэргэшил их эмч-6, дээшлүүлэх их эмч-4, сувилагч олгох-6, дээшлүүлэх-6 тус тус хамрагдсан байна. | 100 |
| 3.1.2 | Орон нутгийн эмнэлгийн мэргэжилтнийг дээд шатлалын эмнэлэгт дадлагажуулан сургах, орон нутагтаа мэргэжлийн | ОНХО | Мэргэжлийн баг урьсан байдал | 3 баг ирсэн. 85 эмч мэргэжилтэн | 3-5 удаа 100 ЭМА | Эмнэл зүйн , стандарт зааврыг сурталчилан эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийн ур чадвар, мэдлэг, чадварыг дээшлүүлэх зориолгоор Мэргэжлийн нийгэмлэг ,лавалгаа төвүүдээс ажлын байранд сургалт 14 удаа, танхимаар 29 удаа цахимаар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | баг урьж ажлын байранд чадавхижуулахад мэргэжлийн холбоодтой хамтран ажиллахад дэмжиж ажиллана. | | хамрагдсан мэргэжилтний тоо | хамрагдсан. | | 18 удаа давхардсан тоогоор 1400 эмч сувилагч Дотоодын сургалт 23 удаа давхардсан тоогоор - 1200 гаруй эмч мэргэжилтэн оролцсон.<br><br>1.Орхон аймгийн хадвар судлалын төв, бүсийн эмчилгээ оношилгооны төв өрхийн ЭМТ эх барих эмэгтэйчүүдийн чиглэлээр туршлага судлах уулзалт зөвөлгөөнд НЭМТ,Өрх сумдын ЭМТ их эмч сувилагч нарын хамтарсан 30 хүний бүрэлдэхүүн бүхий баг 2 хоног хугацаатай ажиллаа<br><br>2.ЭХЭМҮТ-д эх барих эмэгтэйчүүдийн чиглэлээр 04 сард 2 эх баригч бага эмч 1 сарын хугацаатай мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан .<br><br>3. .2026.05.21 өдөр Сүрьеэ, ХДХВ/БЗДХ, гепатитын чиглэлээр нэгдсэн үйлчилгээ үзүүлэх чадавхжуулах бүсийн сургалт Орхон аймагт зохион байгуулахад Эрүүл мэндийн газрын халдварт, сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварын хөтөлбөрийн зохицуулагч эмч нар хамрагдлаа.<br><br>4.Улаанбаатар хот АШУҮИС-ын Монгол анагаах ухааны төв эмнэлгт 2026-03-06-нд Уламжлалтын тасгийн эрхлэгч, ахлах сувилагч, сувилагч нарын нийт 5 хүний бүрэлдэхүүнтэй, тус эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдал, шинэ технологи, ЭМД-ын санхүүжилт, тусламж үйлчилгээний нэр төрөл гэсэн чиглэлээр мэдээлэл солилцож, туршлага судалсан.<br><br>5. Цусны төвийн эмч бага эмч нар ЦССҮТөвөөс жил бүр зохион байгуулдаг Үндэсний семинарт | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2026-03-05,06 нд 2 өдөр цахимаар оролцож туршлага судласан.<br><br>Нэгдсэн эмнэлэг ГССҮТ-ийн эмч нартай хамтран ажиллах гэрээг 2026 оны 03.20 өдөр байгуулан ажлын байранд 10 их эмч сувилагчид сургалтад хамрагдсан байна. | |
| 3.1.3 | Эмнэлгийн мэргэжилтнийг мэргэжлийн чиглэлээр гадаадад богино болон урт хугацааны сургалтад хамруулж чадавхижуулахад дэмжлэг үзүүлж ажиллана. | - | - Сургалтад хамрагдсан мэргэжилтний тоо | - Гадаадад 16 эмч мэргэжилтэн | Гадаадад 16 эмч мэргэжилтэн | 1. 2026.02 сард БНСУ-н Сөүлийн үндэсний их сургуулийн эмнэлэгт Серажем-21 төслийн хүрээнд "Сэргээн засах туслаж үйлчилгээний орчин үеийн тоног төхөөрөмжийг судлах нь" сургалтанд сэргээн засах тасгийн эрхлэгч Ц.Цэндсүрэн, ахлах сувилагч С.Энхжаргал нар хамрагдсан. /2/<br>2. 2026.03 сард Вьетнам улсын ДаНанг хотод зохион байгуулагдсан ОУ-н дүрс оношилгооны ОУ-ын хуралд ДОТ тасгийн эрхлэгч Д.Ариунболд ханын илтгэлээр хамрагдсан. /1/<br>3. 2026.04 сард БНСУ-ын Сөүл болон Инчеон хотод зохион байгуулагдах SICEM-2026 ОУ-ын эрдэм шинжилгээний хуралд 2 төрлийн ханын илтгэлээр Поликлиник-1 тасгийн эрхлэгч Ц.Энхчимэг оролцсон. /1/<br>4. 2026.04 сард Словен улсын Люблана хотод "ESC Preventive Cardiology 2026" ОУХ-д Поликлиник-1 тасгийн зүрхний их эмч Г. Бадамлянхуа оролцсон. /1/<br>5. 2026.05 сард Сетунари ХХК-аас зохион байгуулж буй Customers Experience programm буюу Швейцарь улс дахь ROCHE бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төвтэй танилцах, туршлага судлах хөтөлбөрт ЭЗ-ЭСЛ-ийн тасгийн эрхлэгч М.Мөнхзул хамрагдсан. /1/<br>6. 2026.06 сард БНСУ-ын Бусан хотод болох Kosin University Gospel Hospital-д "IYEA-2026" | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөтөлбөрт Дүрс оношилгооны тасгийн их эмч М.Мандухай, ахлах сувилагч С.Наранчимэг нар хамрагдсан. /2/<br>7. 2026.06 сард БНСУ-ын Сөүл хотод болох "IDEN-2026" хөтөлбөрт Дүрс оношилгооны тасгийн их эмч М.Мандухай, ахлах сувилагч С.Наранчимэг нар хамрагдсан. /2/<br>8. 2026.06 сард Sansure LLC, Пролианс ХХК-аас БНХАУ-ын Чанша хотод зохион байгуулагдах Mongolia China ceminar on Advanced in Vitro Diagnostic and Laboratory technologies -д ЭЗ-ЭСЛ-ийн тасгийн их эмч У.Уранцэцэг хамрагдсан. /1/<br>Үр дүн: Гадаад улсад 8 төрлийн гадаад сургалт, эрдэм шинжилгээний хуралд 11 ажилтан хамрагдсан. | |
| 3.1.4 | Амь тэнссэн үеийн яаралтай болон түргэн тусламжийн чиглэлээр эрүүл мэндийн ажилтны мэдлэг ур чадварыг дээшлүүлэхэд ажлын байрны болон урт богино хугацааны сургалтыг зохион байгуулж, удирдлага мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана. | - | Сургалтад хамрагдсан эмч, мэргэжилтний тоо | 100 | 100 | .“Цэнхэр кодоор тусламж үзүүлэхэд бидний оролцоо” сэдэвт амьлуулах лавшруулсан тусламжийн ур чадварын тэмцээнийг Монголын Яаралтай амилуулах суурь тусламжийн нийгэмлэгтэй хамтран Нэгдсэн эмнэлгийн тасаг нэгжээс 7 багт 60 эмч эмнэлгийн мэргэжилтний дунд зохион байгуулсан. Амь тэнссэн үеийн яаралтай тусламжийн чиглэлээр 50 эмч мэргэжитэн сургалтад хамрагдсан. Аймгийн ИТХ-ын санхүүжилтээр “Тоёота Хайэс” маркийн автомашиныг аймгийн засаг дарга тэргүүтэй аймгийн удирдлагууд /2026-03-03/хүлээлгэн өгсөн бөгөөд нэгдсэн эмнэлгийн удирдлага, санхүү, түргэн тусламжийхан шинэхэн машиндаа зөөврийн амьсгалын аппарат, дефибрилятор, хүчилтөрөгчийн баллоныг суурилуулах ажлыг бүрэн дуусгаснаар зүрх судас болон амьсгалын замын хүнд өвчтөнд газар дээр нь болон | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тээвэрлэх явцад амь тэнссэн үеийн тусламж үзүүлэх боломжтой болсон. | |
| 3.1.5 | Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг тасралтгүй сайжруулах үйл ажиллагааг зохион байгуулах, мэргэжлийн нийгэмлэг, холбоодын оролцоог нэмэгдүүлэх татан оролцуулна. | - | Сургалтад хамрагдсан мэргэжилтний тоо | 476 эмч, мэргэжил тэн | 250 | Эрүүл мэндийн газрын ёс зүйн дэд хорооны хүсэлтийн дагуу Анагаах ухааны Доктор, дэд профессор Хууль зүйн ухааны магистр М.Цэрэнбат эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн эрх зүй, ёс зүйн суурь болон мэргэжлийн мэдлэгийг системтэйгээр нэмэгдүүлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний явцад үүсэж болзошгүй эрх зүйн болон ёс зүйн асуудлыг танин мэдүүлэх, тэдгээрийн шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлсэд дүн шинжилгээ хийх, зөрчил, алдаа дутагдлаас урьдчилан сэргийлэх, мэргэжлийн хариуцлага, ёс зүйн зөв хандлага, харилцааг төлөвшүүлэхэд мэдлэг олгох зорилгоор 200 гаруй их эмч сувилагч нарын дунд сургалт зохион байгууллаа. | 80 |
| 3.1.6 | Эмнэлгийн мэргэжилтний судалгааны ажлыг дэмжиж ажиллана. | - | - эрдэм шинжилгээний судалгааны ажил | 2 удаагийн эрдэм шинжилгээний хуралд 14 судалгааны илтгэл | 10-аас доошгүй судалгааны ажил | Эмнэл зүйн ховор тохиолдолууд -2026,” Эрдмийн чуулган -2026” үйл ажиллагааг зохион байгуулсан. Нийт 12 бүтээл оролцсон .<br>АШУҮИС-ийн Дархан дахь салбар сургуулийн Сувилахуйн тэнхимтэй хамтран 11 дэх жилдээ уламжлал болгон зохион байгуулдаг “СУВИЛАХУЙН ХӨГЖИЛ–2026” бүсийн эрдэм шинжилгээний хуралд Сэлэнгэ, Хөвсгөл, Орхон аймгууд болон Нэгдсэн эмнэлгээс нийт 4-н илтгэл оролцсон. Тэргүүн байрыг МЭЭ тасгийн сувилагч Г.Одончимэг, Халдвартын тасгийн ахлах сувилагч Б.Бямбадорж нарын “Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлгийн сувилагчдын темперамент болон ажлаас халшрах хам шинж хоорондын хамаарлыг судлах нь” Амаржих тасгийн эх баригч Б.Цэндсүрэн, Н.Ёсөнбилэг, Б.Алимаа нарын “Хүүхдээ хөхөөр хооллохын ач холбогдол, хөхөө зөв амлуулах талаар жирэмсэн эхчүүдийн мэдлэг, чадварыг үнэлэх нь” сэдэвт илтгэл батламж хүртлээ. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Гадаад улсад ЭШХ болон ОУХ-д оролцсон байдал:<br>1. Вьетнам улсын ДаНанг хотод зохион байгуулагдсан ОУ-н дүрс оношилгооны ОУ-ын хуралд ДОТ тасгийн эрхлэгч Д.Ариунболд ханын илтгэлээр хамрагдсан.<br>2. БНСУ-ын Сөүл болон Инчеон хотод зохион байгуулагдах SICEM-2026 ОУ-ын эрдэм шинжилгээний хуралд 2 төрлийн ханын илтгэлээр Поликлиник-1 тасгийн эрхлэгч Ц.Энхчимэг оролцсон.<br>3. Словен улсын Люблана хотод "ESC Preventive Cardiology 2026" ОУХ-д Поликлиник-1 тасгийн зүрхний их эмч Г. Бадамлянхуа оролцсон. | |
| **Зорилт 3.2. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллах** | | | | | | | |
| 3.2.1 | Эрүүл мэндийн салбарын албан хаагчдад шагнал, зэрэг дэв, урамшуулал олгоход дэмжиж ажиллана. | УТХО | шагнал урамшуулалд хамрагдсан хүний тоо | -100 | -100 | Эрүүл мэндийн салбарын албан хаагчдад шагнал, зэрэг дэв, үр дүнгийн урамшууллыг улирал бүр олгож байна. Нийт шагнагдсан албан хаагчийн тоо-48. Үүнээс<br>• ЭМЯ-ны шагнал-16 /ЭХТА-9, Жуух бичиг-7/<br>• ДУА ЗДТГ шагнал- 14 /Найрамдлын Дархан-2, Тэргүүний ажилтан-2, Жуух бичиг-10/<br>• Дархан сумын ЗД-ын Жуух бичиг-18 | 90 |
| 3.2.2 | Эмч, ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулж, эмчлэн эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулна. | - | -Үзлэгт хамрагдсан ажилтны тоо<br>-Эрүүлжилтийн хувь | -480 эмнэлгийн ажилтан<br>Эрүүлжилт 61% | -500 Ажилтан Эрүүлжилт 65% | 1. Эмнэлгийн ажилчдын урьдчилан сэргийлэх үзлэгийг 5 сарын 13-наас эхлэн нийт хэвтэн эмчлүүлэх 12 тасаг, амбулаторийн 15 тасгийн нийт 368 ажилтнаас В, С вирус, MRSA шинжилгээ авсанаас элэгний В вирустэй 12 ажилтан, С вирустай 7 ажилтан, MRSA халдвартай 16 ажилтан илэрснийг холбогдох | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэргэжлийн эмчийн хяналт, эмчилгээнд хамруулсан. /Үзлэг үргэлжилж байгаа/<br>2. НЭ-ийн ажилтнуудын хавдрын эрт илрүүлэг үзлэгт хамрагдан Бамбайн ЭХО шинжилгээгээр өөрчлөлттэй гарсан 80 ажилтан дотоод шүүрлийн булчирхайн эмчийн үзлэг, бамбайн даврын шинжилгээнд хамруулсан. Бамбайн даврын шинжилгээнд:<br>• 3-6 сар тутамд бамбайн ЭХО-д хянуулах-47<br>• ЭНМЗ үзүүлэх зөвлөмж-2<br>• Anti-TSH-R шинжилгээ өгөх-4<br>• ХСҮТөв-д оношилгоонд хийлгэх зөвлөмж-10<br>• УНТЭ булчирхайн мэс засалд үзүүлэх зөвлөмж-3<br>• Эмийн эмчилгээнд хамрагдсан-13<br>Үр дүн: Нийт ажилтны эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг-2 зохион байгуулж хамруулсан 448 | |
| 3.2.3 | Эрүүл мэндийн ажилчдын ажиллах таатай орчин нөхцлийг бүрдүүлэх, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангахад дэмжиж ажиллана. | -УТХО | -Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслийн хангалтийн тоо<br>-Зарцуулсан төсөв | -45.9сая | Гүйцэтгэлэ эр | Түргэн тусламжийн 25 ажилтнуудад 6.925.000 төгрөгний үнэ бүхий өвлийн хос хувцасаар хангасан.<br><br>Шилдэг хамт олон шалгаруулах аяны удирдамжийг 1 сарын хугацаатай зохион байгуулж, ХАБЭА-н зөвлөлийн гишүүд дүгнэж шалгаруулсан. ХАБЭА-г дэмжигч шилдэг хамт олноор 1-р байранд МЭЭ тасаг, 2-р байранд Гэмтлийн тасаг, 3-р байранд Амаржих тасаг тус тус шалгарсан.<br>Үр дүн: Аяны хугацаанд хийсэн онцлог ажлаас дурдвал:<br>• Ажилчдын амрах өрөө тохижуулах: Гемодиалезийн хэсэгт ажилчдын амрах өрөөг коридорын хэсгийг ашиглан шинээр хийж, тохижуулсан. /1.997.000 төгрөг/<br>• Эрүүл мэндийн өдөрлөг: Өглөөний алхалт, Эрүүл хоололт, спортын нөхөрсөг тэмцээн | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • Витаминжуулалт: Ажилчдын дархлаа дэмжих зорилгоор витаминжуулалт хийсэн. | |
| *Хүний нөөцийг чадавхижуулах, нийгмийн баталгааг хангах чиглэлээр:2 зорилт 9 арга хэмжээний хэрэгжилт 88.8%* | | | | | | | |
| **4. ЭРҮҮЛ МЭНДИЙН САНХҮҮЖИЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР:** | | | | | | | |
| **Зорилт 4.1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд гүйцэтгэлд суурилсан санхүүжүүлэх тогтолцоог хэрэгжүүлэх** | | | | | | | |
| 4.1.1. | Төсөв санхүүгийн ил тод нээлттэй байдлыг хангана. | - | Шилэн дансны мэдээлэл | Шилэн дансны мэдээлэл 99% | Шилэн дансны мэдээлэл 99% | Салбарын 10 байгууллага шилэн дансанд эхний 6 сарын байдлаар 485 мэдээлэл байршуулахаас Шарын гол СЭМТ 2 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн. Ингэснээр шилэн данс хөтлөлт 99.6% байна. | 99.6% |
| 4.1.2. | Үйл ажиллагааны төсвийн зарлагын хэмнэлт, зардлын бүлэг хооронд шилжүүлэн зарцуулах зохицуулалтыг Төсвийн тухай хуулийн 42, 45, 46 дугаар зүйл, заалтын дагуу Захиалагчид бичгээр хүсэлт гаргаж шийдвэрлүүлнэ. | - | Албан бичгийн тоо | 3 | Тухай бүр | 2026 оны төсөв батлагдсанаас хойш төсөвт 2 удаа зохицуулалт хийлгэх санал хүргүүлсэн. Хамгийн сүүлд ЭМДҮЗ-ийн 2026 оны 01 дүгээр тогтоол гарч анхан шатны эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний тариф шинэчлэгдсэнтэй холбоотой ЭМЯ-аас өгсөн чиглэлийн дагуу сумдын төсвийг 5-р сараас нэмэгдсэн төсвийн дагуу зохицуулалт хийхээр хүргүүлсэн. СЭМТ-ийн төсөв 9,664.9 сая төгрөг байснаас 10,983.2 сая төгрөг буюу 13.6 хувиар өссөн. Тус зохицуулалтаар Нэгдсэн эмнэлгийн төсөв 28,536.5 сая төгрөг байснаас 27,386.5 сая төгрөг болж буурсан. Аймгийн эрүүл мэндийн салбарын 2026 оны анхны батлагдсан төсөв 35,646.3 сая байснаас 5-р сарын төсвийн байдлаар 42,859.8 сая төгрөг болж 7,213.5 сая төгрөг болж нэмэгдсэн байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.3. | Эрүүл мэндийн байгууллагуудын өр, авлагын байдалд хяналт тавин ажиллаж Төсвийн тухай хуулийн 6.2, 6.3, 6.4 болон 16.5.2, 16.5.3, 16.5.5, 57.5-д заасныг мөрдлөг болгон өр, авлага үүсгэхгүй ажиллана. | - | Өр авлагагүй байх | Өр авлагагүй ажилласан | Өр авлагагүй ажиллах | Нэгдсэн эмнэлэг, СЭМТ-үүдийн хувьд 2026 оны 01-р сарын 1-нээс цалин 30% өссөн боловч эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тариф нэмэгдээгүйгээс өр хуримтлагдсан. 2026 оны 4 сараас анхан шатны эмнэлгүүдийн тусламж, үйлчилгээний тариф нэмэгдэж ЭМДҮЗ-ийн тогтоол шинэчлэгдэн батлагдаж өр буурч байгаа боловч барагдаж дуусаагүй байна. Харин лавлагаа шатлалын эмнэлгийн тарифтай холбоотой ЭМДҮЗ-ийн тогтоол одоогоор батлагдаж хэрэгжиж эхлээгүй байгаагаас Нэгдсэн эмнэлгийн өр өссөн. Ялангуяа 2026 оны 05-р сарын 01-нээс ЗГ-ын 135-р тогтоолоор цалинг тогтоосноор ажилтны үндсэн цалин нэмэгдээгүй ч нийт цалин нэмэгдсэн нь цалингийн зардлыг улам өсгөсөн боловч тусламж, үйлчилгээний тариф нэмэгдэж шинэчлэгдэн батлагдаагүй нь өрийг улам нэмэгдүүлж байна. 2026 оны 5-р сарын байдлаар өрийг байгууллагаар нь авч үзвэл:<br>Эрүүл мэндийн газар 35.7 сая<br>Нэгдсэн эмнэлэг 6,209.4 сая<br>Хонгор СЭМТ 85.7 сая<br>Орхон СЭМТ 95.7 сая<br>Шарын гол СЭМТ 253.4 сая<br>Нийт салбарын өр 6,679.9 сая төгрөг байна. | 90% |
| ***Эрүүл мэндийн санхүүжилтийн чиглэлээр: 1 зорилт 3 арга хэмжээний хэрэгжилт 96.5%-тай байна.*** | | | | | | | |
| **5. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТЕХНОЛОГИЙН ЧИГЛЭЛЭЭР:** | | | | | | | |
| **Зорилт 5.1. Тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад шаардлагатай хөрөнгө оруулалтыг дэмжиж ажиллах** | | | | | | | |
| 5.1.1 | Зайлшгүй шаардлагатай хөрөнгө оруулалт бусад дэмжлэгийг Аймгийн Засаг даргын нөөц сан, орон нутгийн төсвийн хөрөнгө, орон нутгийн хөгжлийн сангаас шийдвэрлүүлэх | УТХО | Тоног төхөөрөмж | 1.100.0 | Гүйцэтгэлээр | Орхон СЭМТ-ийн лабораторийн үйл ажиллагаанд зориулж сумын Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 5.0 сая төгрөгөөр иммунологийн аппарат авч өгсөн.<br>Нэгдсэн эмнэлэгт Орон нутгаас<br>- Эмгэг нярайн тоног төхөөрөмж 15 нэр төрөл 98.4 сая; | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | талаар санаачлагатай ажиллана.(мэс заслын болон эмгэг нярайн тоног төхөөрөмж,ургийн доплер, гемодиалез) | | | | | - Түргэн тусламжийн автомашин 1ш 133.7 сая;<br>- Ургийн монитор 10 ш 36.0 сая төгрөг;<br>- Мэс заслын багаж тоног төхөөрөмж 32 нэр төрөл 464 ширхэг 119.6 сая төгрөг;<br>ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар Маммографийн аппарат 1 ш 392.0 сая төгрөг. | |
| ***Эрүүл мэндийн технологийн чиглэлээр: 1 зорилт 1 арга хэмжээний хэрэгжилт 100%-тай байна.*** | | | | | | | |
| **6.ЭМЗҮЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР:** | | | | | | | |
| **Зорилт 6.1 “Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн, цахим бүртгэл, хяналтыг сайжруулж, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх” зорилтын хүрээнд** | | | | | | | |
| 6.1.1 | Эмийн цахим жор бичих эмч нарт эрх олгох, хаах үйл ажиллагааг зохион байгуулж, энгийн болон мансууруулах сэтгэцэд нөлөөт эмийн жор, жор бичилтэд хяналт тавьж ажиллана. | - | Цахим жор бичиж буй эмч Жор бичилтэд хяналт тавьсан байдал | 216 эмч 1 удаа | 216 эмч 1 удаа | https://health.gov.mn/app-д Нэгдсэн, өрх, сумын нийт 518 ажилтан бүртгэлтэй байна.<br><br>Эмийн цахим жор бичих эмч нарт эрх олгосон 10, эрх хаасан 5 байна. Энгийн болон мансууруулах сэтгэцэд нөлөөт эмийн жор, жор бичилтэд хяналт тавьж ажиллаж байна. 2026 оны 06.10-ны байдлаар нийт мансууруулах-220ш, сэтгэцэд нөлөөт эмийн 50ш нийт 270 ш түгээсэн байна.<br><br>Тусгай зөвшөөрөл бүхий 77 эмийн сан эм цахим жороор олгохоор ЭЭХХЗГ,ЭМДЕГ-тай гурвалсан гэрээ байгуулж 70 эмийн сан цахимаар олгогдох боломж хангагдсан.2026 онд шинээр тусгай зөвшөөрөл олгогдсон 7 эмийн сан гэрээг хийж ЭЭХХЗГ-т хүргүүлсэн байна. | 100 |
| 6.1.2 | Эмийн зохистой хэрэглээний талаарх ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны арга | - | Хамрагдсан эмч мэргэжилтэн, үйлчлүүлэгчийн тоо | Эмнэлгийн ажилтан 226 | 250 эмч эмнэлгийн мэргэжилтэ | New veramed ХХК-с эмийн сангийн эмзүйч мэргэжилтэнүүдэд “Ахмад настанд зонхилон тохиолдох хам шинжийн менежмент” сэдвээр 105 хүнийг хамруулсан 2 кредиттэй, KRKA эмийн компаниас “Цочмог өвдөлтийн менежмент” | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэмжээ хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүй, зохион байгуулалтаар хангаж ажиллана. | | | Үйлчлүүл эгч 2000 | н, 1000 иргэн | сэдвээр 110 эмч,эмүйч хамруулсан 1 кредиттэй сургалт зохион байгуулсан. Иргэдэд Эмийн зохистой хэрэглээний талаарх ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн мэдээллийг 854 хүнд хүргэсэн байна.<br><br>Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/414 дүгээр тушаалаар батлагдсан “Эмийн эмчилгээг зохицуулах хороо”-ны ажиллах журам нь Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/28 дугаар тушаалаар "Эмийн эмчилгээний хороо болон бичил биетний эсрэг эмийн дэд хороо" -ны ажиллах журам болж, шинэчлэгдэн батлагдсан. Шинэчлэгдсэн журмын дагуу тус хорооны 2025 оны тайланг нэгдсэн эмнэлгээс авч хянан ЭЭХХЗГ-т албан тоот болон info@mmra.gov.mn цахим хаягаар хугацаанд хүргүүлсэн.<br><br>Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр батлагдсан “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 04 дүгээр тогтоолын тавдугаар хавсралтад заасны дагуу Төрөөс төлбөрийг нь хариуцах эмийн 2025 оны дөрөвдүгээр улирлын тайланг ЭЭХХЗГ-т албан тоот болон ankhzaya@mmra.gov.mn цахим хаягаар хугацаанд хүргүлсэн.<br><br>Эмзүй албаны зохион байгуулалт, менежмент сургалтад үйл ажиллагаа явуулж байгаа эмийн сангийн 5 эм зүйчийг цахимаар суралцах хүсэлтийн дагуу ЭМГ даргын албан тоот | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | АШУҮИС-ын Эмзүйн сургуульд хүргэж суралцах боломж бүрдүүлсэн.<br><br>Нийт 77 эмийн сангийн хүний нөөцийн хангалтыг "Эрүүл мэндийн ажилтны нэгдсэн бүртгэлийн сан" hr.hdc.gov.mn программаас тулгалт хийлээ. Программд бүртгэлгүй-6, хүний нөөц дутуу оруулсан болон баталгаажилт хийгээгүй газрууд-27 байна. (Нэг бүрчлэн залгаж утсаар мэдэгдсэн болно.) Эдгээр газрууд 2026.03.10-ны дотор бүртгэлээ хийлгэж, хүний нөөцөө бүртгэж баталгаажуулах үүрэг өгсөн. Үйл ажиллагаа зогссон 5 эмийн сан байна. | |
| 6.1.3 | ЭМБ-уудын эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн бэлэн байдал чанар аюулгүй байдалд тогтмол хяналт тавьж ажиллана | - | Нөөц бүрдүүлэлт | 1-2 сарын нөөцтэй | 1-2 сарын нөөцтэй | Эрүүл мэндийн сайдын 2020 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн А/490 тоот тушаалын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2026 онд шаардлагатай Өндөр тунт А аминдэмийн захиалгыг бүтэн жилээр тооцон, тушаалын хавсралтад заасан маягтын дагуу өрх сумын эрүүл мэндийн төвүүдээс авч нэгтгэн НЭМҮТ-д албан тоотоор хүргүүлсэн. Үүнд: 6-11 сартай хүүхэд жилд 1 удаа уухаар 100,000ОУН-2190ширхэг, 12-59 сартай хүүхэд жил 2 удаа давтан уухаар 14,744 ширхэг захиалсан.<br><br>Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд ЭМС-ын А/490 тоот “Аминдэм эрдсийн бэлдмэл хэрэглэх заавар” тушаалын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Жирэмсний Олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэлийн 2026 оны захиалгыг өрх сумаар нэгтгэн №180-682 флаконыг захиалсан. Жирэмсэн эмэгтэйчүүдэд түгээсэн олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэлийн (ОНБТБ) | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2025 оны 12, 2026 оны 1,2 сард түгээсэн тайланг авч нэгтгэн хугацаанд нь хүргүүлсэн. Хүүхэд, эмэгтэйчүүдийг аминдэм, эрдсийн дутлаас сэргийлэх зорилгоор батлагдсан Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/490 дугаар тушаал, мөн жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлэх, худалдан авах, зарцуулах, тайлагнах журмыг баталсан Эрүүл мэндийн сайдын А/11 дүгээр тушаал-ын хэрэгжилтийг хангах зорилгоор хяналт-үнэлгээг<br><br>ЭМГ даргын баталсан удирдамжийн дагуу 2026.03.17-03.20-ны хооронд Өрх, сумын ЭМТ-үүдэд ЭМГ-ын ЭМТҮХ-ийн хүүхдийн мэргэжилтэн, ЭМГ-ын НЭМТ-ийн ЭХНҮЭМ-ийн зохицуулагч эмчтэй хамтран хийж хяналт үнэлгээгээр 54,5 буюу сайжруулах шаардлагатай дүгнэгдэж зөвлөмжийг ЭМГ-ын даргын албан тоотоор өрх сумын ЭМТ-д хүргүүлсэн.<br><br>Эрүүл мэндийн сайдын 2026 оны 05 сарын 05-ны өдрийн а/171 тушаалаар Эрүүл мэндийн яамнаас хуваарилсан 4,178,992,16 (дөрвөн сая нэг зуун далан найман мянга ёсөн зуун ерэн хоёр төгрөг арван зургаан мөнгө) төгрөгийн үнийн дүн бүхий 6-59 сартай хүүхдэд уулгах өндөр тунт А аминдэмийн татан авалт хийж, өрх сумын ЭМТ-үүдэд 5 сард тараах хүүхдийн судалгааны авч ЭМГ даргын тушаалаар 6-11 сартай 1171 хүүхэд, 12-59 сартай 7394 хүүхдэд уулгахаар 100,000 ОУН-1000ш, 200,000 ОУН-7480 ширхэг хуваарь хийж түгээсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6.1.4 | Эрүүл мэндийн байгууллагын эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээ, тохируулга хийсэн байдалд хяналт тавьж ажиллана. | - | Засвар, тохируулга хийсэн тоо | 85 багаж тоног төхөөрөмж | Шаардлагатай тоног төхөөрөмжийн тоогоор | Дархан-Уул аймгийн стандарт хэмжил зүйн газарт 1,983,100 төгрөгийн зардлаар 145 ширхэг багаж, хэрэгслийг баталгаажуулсан.<br><br>Нийт 40 литрийн 20 ширхэг хүчилтөрөгчийн баллоны баталгаажуулалтыг 2,420,000 төгрөгөөр хийлгэсэн. | 100 |
| 6.1.5 | Эм зүйн салбарт мөрддөг хууль, стандартын хэрэгжилтийг хангуулахад мэргэжил арга зүй, дэмжлэгт удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллана. | УТХО | Хяналт үнэлгээ хийсэн байгууллагын тоо | ЭХНБ, эмийн сан 42 | 15 | ЭМС-ын А/408 журмын хэрэгжилтэд Дархан -Уул аймгийн Цагдаагийн газар, Тагнуулын газартай хамтарсан хяналт үнэлгээг<br>мансууруулах эм худалдах тусгай зөвшөөрөл бүхий Энхийн тун, Өлзий амгалан, Ариунмаргад, түүвэрчилсэн байдлаар<br>Гоофарм, Очиртуяа, Гишүүт, Анагаах тун, Монос-3 эмийн сангуудад габапентин найрлага бүхий эмэнд,<br>Нэгдсэн эмнэлгийн мэдээгүйжүүлэх тасаг, Түргэн тусламж. Эмзүйн алба, Дотрын тасагт хянал үнэлгээ хийж үнэлгээгээр илэрсэн зөрчил дутагдал арилгуулах зөвлөмж өгч ажилласан. | 73.3 |
| ***Эмзүйн тусламж үйлчилгээний чиглэлээр 1 зорилт 5 арга хэмжээний хэрэгжилт 92.6% байна.*** | | | | | | | |
| **7. МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ЧИГЛЭЛЭЭР:** | | | | | | | |
| **Зорилт 7.1. Хувь хүн, байгууллага, эрүүл мэндийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах** | | | | | | | |
| 7.1.1. | Эрүүл мэндийн байгууллагуудад цахим мэдээллийн аюулгүй байдлын 4 багц хууль (Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль)-ийн хэрэгжилтийг хангаж ажиллана. | - | Сургалтад хамрагдсан ажилтны тоо | 150 | 80 | Кибер аюулгүй байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр: Эрүүл мэндийн газрын 21, сум өрхийн 24, Нэгдсэн эмнэлэг 36 албан хаагчийг хамруулан дараах сэдвүүдээр сургалт зохион байгууллаа. Үүнд: -“Төрийн албанд дижитал технологи ба хиймэл оюуны хэрэгслүүдийг үр ашигтай ашиглах нь”;-“Албаны болон хувь хүний мэдээллийн аюулгүй байдал”. Сургалтаар байгууллагын болон иргэдийн мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдал, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүртээмжийг хангах, кибер халдлагаас урьдчилан сэргийлэх, мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийг бууруулах, хүний хувийн мэдээллийг хууль тогтоомжийн дагуу хамгаалах талаар мэдлэг, ур чадварыг дээшлүүлсэн.<br><br>Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр:Цахим баримт бичгийн эргэлтийг нэмэгдүүлэх, төрийн үйл ажиллагааны цахим шилжилтийг дэмжих зорилгоор Эрүүл мэндийн газар болон Аймгийн нэгдсэн эмнэлгийн удирдлагууд 2026 оноос эхлэн тоон гарын үсгийг албан үйл ажиллагаандаа ашиглаж эхэлсэн. | |
| 7.1.2. | Эрүүл мэндийн байгууллагуудад ХАБЭА-н хуулийн хэрэгжилтийг хангуулж, мэргэжил арга зүйгээр хангаж, хяналт тавьж ажиллах | - | Зохион байгуулсан үйл ажиллагаа | 10 | 10 | ХАБЭА-ын чиглэлээр дараах суралтыг зохион байгуулсан.<br>1. Даралтат савны аюулгүй ажиллагааны сургалтанд 450мян.төгрөгөөр хүчилтөрөгчийн 3 техникчийг хамруулж, гэрчилгээжүүлсэн.<br>2. Ажлын байранд эрсдлээс сэргийлэх сургалтыг 4 удаа хийж 125 ажилтан хамруулсан.<br>3. Шинэ ажилтантанд ХАБЭА-н чиглэлийн 6 төрлийн сургалтанд 165 ажилтан хамрагдсан.<br>4. 4 сард ОБГ-ын урьдчилан сэргийлэх, эрсдэлийн үнэлгээ хариуцсан мэргэжилтэн, ахлах дэслэгч Ч.Лхамсүрэнтэй хамтран “Галын аюулаас урьдчилан сэргийлэх” сэдвээр хийсэн сургалтанд 45 ажилтан хамрагдсан.<br>5. Эмнэлгийн техник технологийн академи сургалтын төвөөс зохион байгуулсан сургалтанд удирдах ажилтан 2, ХАБ-ын зөвлөлийн гишүүн 3 нийт 5 ажилтан хамрагдсан. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 6. ЭМХТөвтэй хамтарсан тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны сургалтанд эмч, сувилагч 65, бусад ажилтан 20 хамрагдсан. Нийт 85 ажилтан<br>Үр дүн: 6 төрлийн сургалтанд нийт 428 ажилтан хамрагдсанЭМГ-аас санаачилсан ДУА-ын Эрүүл мэндийн байгууллагуудын дунд зарласан “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн аян”-ыг өөрийн байгууллагад зохион байгуулсан. Аяны хүрээнд 12 ажил төлөвлөж 92.5% байна. | |
| **Зорилт 7.2. Эрүүл мэндийн салбарын мэдээллийн технологийг хөгжүүлэх** | | | | | | | |
| 7.2.1 | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд алсын зайн оношилгоо, зөвөлгөө, мэдээлэл солилцох (теле медицин) тусламж үйлчилгээ авах тоног, төхөөрөмж интернэтээр ханган ажиллана. | УТХО | -тоног төхөөрөмжийн хангалт<br>-тусламж үйлчилгээ авсан иргэд | www.pacs.mn ашиглалт 100% нэвтэрсэн. КТГ 94 тохиолдолд зөвөлгөө авч ажилласан | -Шаардлагатай тохиолдол бүрт | Улсын Хоёрдугаар төв эмнэлэг,Улсын гуравдугаар эмнэлгийн зайн оношилгооны төвтэй холбогдож зүрх судас, мэдрэлийн мэс засал, зүрхний шигдээс, тархины харвалт, чиглэлээр хамтран ажиллаж алсын түргэн тусламжийн үйлчилгээг 4 удаа авч хамтран хагалгааг орон нутагтаа хийж ,онош тодруулах хагалгаанд оруулахаар яаралтай журмаар 21 өвчтөнг шилжүүлэн яаралтай тусламж үйлчилгээг үзүүлсэн байна | 100 |
| 7.2.2 | Эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээнд эмчийн үзлэг, өвчний түүх, цаг авах, шинжилгээ авах, өвчтөн илгээхтэй холбоотой цахим соёлыг төлөвшүүлнэ. | - | Цахим системийн хамралт | 100 хувь цахимжсан | 100% | Анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд Нэгдсэн эмнэлэг хооронд өвчний хяналт хийх,эргэн мэдээлэх программ хангамжийн сайжруулах зорилгоор ЭМГ-ийн удирдлагын зөвлөлийн шийдвэрийн 2026 оны 05 сарын 01 ны өдрөөс эхлэн Нэгдсэн Карте программд шилжүүлэн ажиллаж байна. | 90 |
| ***Мэдээллийн технологийн чиглэлээр: 2 зорилт 4 арга хэмжээний хэрэгжилт 95%-тай байна.*** | | | | | | | |
| **8. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ИЛ ТОД БАЙДАЛ** | | | | | | | |
| **Зорилт 8.1. Эрүүл мэндийн салбарын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгож, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулахад төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний ил тод байдлыг хангаж ажиллах** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 8.1.1 | Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагатай төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ байгуулж эмнэлгийн ачаалал хуваалцах, тусламж үйлчилгээний тасралтгүй, шуурхай хүртээмжтэй байдлыг хангаж ажиллана | - | -Ачаалал хуваалцсан хувь | Нийт үзлэгийн 21% | 21%-иас доошгүй байх | Нийт 326103 үзлэг хийгдсэнээс хувийн хэвшлийн нийт үзлэг 59657 буюу 18.2% эзлэж улсын эмнэлгийн ачааллыг 18.2% бууруулсан байна. Нийт хувийн хэвшлийн үзлэгээс Шүдний үзлэг 48.6% Эмэгтэйчүүдийн үзлэг 12.6% Уламжлалт сэргээн засахын үзлэг 2.2% тус тус эзлэж байна. Нийт хэвтсэн эмчлүүлэгчийн 23.7%, Лабораторийн шинжилгээний 15.2%-ийг ХХЭМБ хийж тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. | 100 |
| 8.1.2 | Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуй нэгж байгууллагын асуудлыг цахимаар авч шийдвэрлэн ажиллана. | - | Баталсан тушаалын тоо -ААНБ тоо | Тушаал-15 Байгууллага 47 | Тухай бүр | Монгол улсын тэргүүн шадар сайд бөгөөд эдийн засаг, хөгжлийн сайдын 2025.08.27-ны 01/2333 албан тоот, ЭМЯ-ны 2025.09.03-ны 5/4257 албан тоот, Зөвшөөрлийн тухай хуулийн 7.1-д заасан чиг үүргийн дагуу Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох, сунгах, түтгэлзүүлэх асуудлыг тусгай зөвшөөрлийн цахим сан https://license.mn-p, байршил солих болон гэрчилгээнд өөрчлөлт оруулах бусад асуудлыг цаасаар ирүүлсэн албан хүсэл дагуу шийдвэрлэж байна.<br>1. Өрнөн дэвжих хангай ХХК-д шинээр тусгай зөвшөөрөл хүссэний дагуу зөвшөөрлийн цахим системээр дамжуулан шийдвэрлэсэн.<br>2.Шарын гол сумын Тулга сувилал ОНӨААТҮГ-с ирүүлсэн 2026.02.13 07 дугаар албан тоотын дагуу Тус сувилал нь Нийгмийн даатгалын ерөнхий газраас зохион байгуулсан ССШ-01/2026 дугаартай Үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас санхүүжих сувиллын сонгон шалгаруулалтад оролцож буй тул тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа тогтвортой явуулж байгаа тухай тодорхойлолт гарган хүргүүлсэн.<br>3.Нэгдсэн эмнэлгээс ирсэн 2026.02.25 1/153 албан тоотын дагуу эмнэлгийн тусгай | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зөвшөөрлийн гэрчилгээний “Төрөлжсөн нарийн мэргэжлийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ чиглэлийг” эрүүл мэндийн газрын даргын тушаалаар эмнэлгийн мэргэшсэн тусламж нэмэлт өөрчлөлт оруулан гэрчилгээнд шивэлт хийж хүлээлгэн өгсөн.<br>4.Ханбулагтай ХХК Болор зүү уламжлалтын эмнэлгээс 2026.03.24-ны 18 дугаар албан тоотоор ирүүлсэн хүсэлтийн дагуу тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулсан. 2026 онд ЭМГ-ын даргын баталсан 6 удаагийн удирдамжийн дагуу “Батцагаанбуянт”ХХК-ний “Буянтай” хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд чиглэл нэмэх , “Өлзий амгалан орших” ХХК-ний “Золбоо-2 ” салбар шинээр эмийн сангийн үйл ажиллагаа эрхлэх, “Арчун мед” ХХК-ний “Арчун мед” шинээр уламжлалтын үүдэн клиник эмнэлгийн үйл ажиллагаа эрхлэх, Танан тээрэм дент” ХХК-ний“ГОЁЛ ДЕНТ” шүдний эмнэлэг үйл ажиллагаа эрхлэх , “БЭНАТ РАЙЗИ” ХХК-ний “Aurora”Арьс гоо засал, пластик гоо заслын эмнэлгийн үйл ажиллагаа, “Өрнөн дэвжих хангай ”ХХК-ний “Хангай ортой клиник” эмнэлгийн үйл ажиллагаа эрхлэх, “Булган нар дөл”ХХК- “Дөл дент” шүдний эмнэлгийн байршил солих, “Энхийн ундраа аз” ХХК-ний Аз фарм эмийн сангийн үйл ажиллагаа эрхлэх хүсэлтийн дагуу нийт 8 байгууллагад шинжээчийн үнэлгээг хийж шинээр 4 байгууллагат зөвшөөрлийн цахим системээр зөвшөөрлийг шинээр олгож, цаасаар ирүүлсэн хүсэлтийн дагуу холбогдох хууль дүрэм журам стандартын хүрээнд шийдвэрлэж ажилласан байна.<br>Үр дүн: Шинээр олгосон тусгай зөвшөөрөл – 9<br>Чиглэл нэмсэн, өөрчилсөн – 2<br>Байршил өөрчилсөн – 4<br>Түдгэлзүүлсэн – 1 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хүчингүй болгосон – 1 Гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулсан – 2 Тодорхойлолт олгосон – 1 | |
| 8.1.3 | Эрүүл мэндийн салбарын хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний стандарт, удирдамжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх, мэргэжлийн удирдлага арга зүйн дэмжлэг үзүүлнэ | УТХО | -Үнэлгээний дундаж хувь | дундаж үнэлгээ 88.4% | Үнэлгээний хувь 89.0% | Эрүүл мэндийн газрын даргын 2026 оны 3 сарын 13 өдрийн А/25 тоот тушаалаар "Эрүүл мэндийн байгууллагуудын тусламж үйлчилгээний эрүүл мэндийн бодлого, хөтөлбөр, стандартын хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх удирдамж"-ийн дагуу хяналт үнэлгээ хийхэд өрхийн эрүүл мэндийн төвийн дундаж үнэлгээ 93.1%, сумын эрүүл мэндийн төвийн дундаж үнэлгээ 86.1%, Нэгдсэн эмнэлэг 92% буюу нийт дундаж үнэлгээ 90.4%-тай байна. | 100 |
| 8.1.4 | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний ил тод, нээлттэй байдлыг хангана.<br>-Хүний нөөцийн<br>-Үйл ажиллагааны<br>-Төсөв, санхүүгийн<br>-Мэдээллийн | - | -Хэрэгжилтийн хувь | 86.6% | 90% | Төрийн байгууллагуудын цахим систем болох www.gov.mn платформд байгууллагын эрх үүсгэх, мэдээлэл байршуулах, шинэчлэх арга зүйн сургалтыг 3 сумын Эрүүл мэндийн төв, 5 өрхийн Эрүүл мэндийн төвийн бага эмч, нягтлан бодогч, нярав зэрэг нийт 17 албан хаагчид зохион байгуулж байгууллагын цахим хуудас мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах чадавхтай болж, www.shilen.gov.mn системд мэдээллийг тогтмол байршуулж, үнэлгээнд амжилттай хамрагдсан.<br><br>Дархан-Уул аймгийн Эрүүл мэндийн газар нь www.shilen.gov.mn системд дараах үндсэн 5 чиглэлээр үнэлгээнд амжилттай хамрагдсан. Үүнд:<br>• Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал - 94.91%<br>• Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал - 80.95% | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал - 93.06%<br>• Үзүүлж буй үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал - 87.5%<br>• Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал - 83.33%<br>Нийт 2026 оны 1-р улиралд – **90.91%** тай үнэлэгдэж иргэдийн мэдээлэл авах эрхийг хангах нөхцөл бүрдсэн. | |
| **Зорилт 8.2. Эрүүл мэндийн байгууллагуудад өргөтгөл, засвар үйлчилгээ хийх, орчин нөхцөлийг сайжруулах, тоног төхөөрөмжөөх хангахад дэмжиж ажиллах** | | | | | | | |
| 8.2.1 | Төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламж, ашиглалт, засвар үйлчилгээтэй холбоотой зардлыг орон нутгийн төсвийн хөрөнгө, орон нутгийн хөгжлийн сангаас шийдвэрлүүлэн ажиллана. (МЭЭ тасгийн засвар) | УТХО | Зарцуулсан төсөв | 1.254.4 | Гүйцэтгэлэ эр | Нэгдсэн эмнэлгшийн байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, урсгал засварын зардлыг аймгийн төсвөөс санхүүжүүлж байна. 2026 оны батлагдсан төсөв 1,049.1 сая төгрөг, 5-р сарын байдлаар 370.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.<br>Гамшгийн эрсдлийг бууруулах бууруулах орон нутгийн зөвлөлөөс Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасагт 2,500.0 мянган төгрөгөөр 5 ширхэг пульсоксиметр болон 2, 3 дугаар давхрын нийт 31 цонхонд 2,945.0 мянган төгрөгөөр хамгаалалт хийж нийт 5,445.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон.<br>Дархан-Ус суваг ХК-иас 7,816.2 мянган төгрөгөөр хүүхдийн тасагт сантехникийн шугамын засварын ажил хийж өгсөн. | 100% |
| 8.2.2 | Сумын эрүүл мэндийн төвийн байр ашиглалт, урсгал засварын зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, баг, сумын эрүүл мэндийн төвийн эмч нарыг дулаан хувцсаар | УТХО | Зарцуулсан төсөв | 1.168.1 | Гүйцэтгэлэ эр | СЭМТ-үүдийн байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, урсгал засварын зардлыг тухайн орон нутгийн буюу сумын төсвөөс санхүүжүүлж байна. 2026 онд Хонгор СЭМТ-ийн байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, урсгал засварын зардлын батлагдсан төсөв 110.0 сая төгрөг, 5-р сарын байдлаар 51.7 сая төгрөгийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хангах, автомашины засвар үйлчилгээг шийдвэрлэн ажиллана. | | | | | санхүүжилт олгосон, Орхон СЭМТ-ийн байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, урсгал засварын зардлын жилийн батлагдсан төсөв 97.1 сая төгрөг, 5-р сарын байдлаар 47.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон, Шарын гол СЭМТ-ийн байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, урсгал засварын зардлын зардлын жилийн батлагдсан төсөв 770,9 сая төгрөг, 5-р сарын байдлаар 334.8 сая төгрөгийн санхүүжилт тус тус олгосон байна. СЭМТ-үүдэд 5-р сарын байдлаар нийт 434.2 сая төгрөгийн санхүүжилт олгосон ба санхүүжилт хэвийн явагдаж байна. | |
| **Зорилт.8.3 Салбарын хяналтыг хэрэгжүүлэх замаар хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулан хүний эрүүл, аюулгүй амьдрах, ажиллах, сурах орчин нөхцөлийг бүрдүүлж ажиллах** | | | | | | | |
| 8.3.1 | Хяналт шалгалтын обьектод шалгуур үзүүлэлтээр эрсдэлийн үнэлгээ хийн, обьектын эрсдэлийн үнэлгээ, хяналт шалгалтын төлөвлөлт, хяналтын хуудасны нэгдсэн сангийн мэдээллийг шилэн хяналтын системд оруулна. | Улсын төсөв | Хяналтын чиглэлд хамаарах үйл ажиллагаа явуулж буй обьектын тоо Шилэн хяналтын системд оруулсан мэдээллийн тоо | 1235 обьект хамрагдсан.<br><br>Шилэн хяналтын системд 1235 обьектын мэдээлэл оруулсан. | 1278 обьект | Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн оношилгоо, эмчилгээний чанар, аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудсанд өөрчлөлт оруулахаар 3 санал, Хог хаягдлын менежментийг шалгах хяналтын хуудсанд өөрчлөлт оруулахаар 4 санал, Согтууруулах ундаагаар үйлчлэх хоол үйлдвэрлэл үйлчилгээний газрыг шалгах, Согтууруулах ундаа худалдах худалдааны газрын үйл ажиллагааг шалгах хяналтын хуудсанд өөрчлөлт оруулахаар 1 санал, нийт 8 саналыг Эрүүл мэндийн яамны Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт цахимаар хүргүүлсэн.<br>2026 онд төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах 52 обьектын төлөвлөлтийг шилэн хяналтын цахим системд оруулсан.<br>2026 оны 4 дүгээр улиралд хийгдэнэ, хугацаа болоогүй | 100% |
| 8.3.2 | Их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн нийт 52 обьектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийнэ. | Улсын төсөв | Хяналт шалгалт хийсэн обьектын тоо | 100% | 100% | 2026 онд төлөвлөсөн 52 обьектоос эрүүл мэндийн 11, ахуйн хог хаягдал цуглуулах, устгах-3, боловсролын 7 байгууллага, хүнсний үйлдвэрлэлийн-2, хоол үйлдвэрлэлийн-5 нийт 28 | 82.8% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хэрэгжилтийн хувь | | | обьектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, 2 обьектыг шалгах хугацаа болоогүй, 2 обьект үйл ажиллагаагаа зогсоосон, хамрагдалт 58.3%-тай байна.Шалгалтаар нийт 376 зөрчил илрүүлж, 105 буюу 27.9%-ийг шалгалтын явцад арилгуулж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар нийт 10 байгууллагад 153 заалттай албан шаардлага хүргүүлэн, 2 албан шаардлагын биелэлт-33.3%-тай, 8 албан шаардлагын 146 заалтын биелэлт ирүүлэх хугацаа болоогүй байна.Төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдсан 13 обьектоос ундны усны-20, агаарын-40, гадаргуугийн арчдасны-165, хоолны-13, ариун материалын-4, хүнсний бүтээгдэхүүний-1 нийт 243 дээжийг лабораторийн шинжилгээнд хамруулахад 175 дээж нь чанар, эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлтээр стандартын шаардлага хангасан үзүүлэлттэй гарсан, 68 дээжний хариу гараагүй байна.Төлөвлөгөөт хяналт шалгалтын явцад 13 төрлийн хяналтын хуудсаар эрсдэлийг үнэлэхэд 4 нь их, 10 нь дунд, 11 нь бага эрсдэлтэй үнэлэгдэж, 3 обьектын эрсдэлийн үнэлгээ гараагүй шалгалт үргэлжилж байна.Холбогдох 9 хуулийн 23 заалтын хэрэгжилт 62.4%-тай байна. | |
| | | | Хууль тогтоомжийн хэрэгжилт (хувиар) | 76.5% | 77.5% | | |
| | | | Зөрчил шийдвэрлэлт (хувиар) | 64.1% | 65% | | |
| | | | Эрсдлийн түвшин буурсан обьектын хувь | Их-3 /17.3%/ Дунд-9 /21.1%/ | Их- 2/12%/ Дунд-7 /16.3%/ | | |
| 8.3.3 | Хяналтын 9 чиглэлээр урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийнэ. | Улсын төсөв | Хяналт шалгалт хийсэн обьектын гүйцэтгэлийн хувь | 94.1% | 95% | 2026 оны төлөвлөгөөнд 9 төрлийн удирдамж бүхий урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийгдэхээс МУЗГ-ын 2026 оны 115 дугаар тогтоол гарсантай холбогдуулан 2 төрлийн урьдчилан сэргийлэх хяналт хийхийг зогсоосон, 2 төрлийн урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх хугацаа болоогүй ба 5 төрлийн урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийгдэж байна.Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтаар 79 аж ахуйн нэгж, 84 иргэний нийт 135 обьектыг хамруулж, 270 зөрчил, дутагдал илрүүлж, 198 буюу 73.3%-ийг хяналт шалгалтын явцад болон гүйцэтгэлийн шалгалтаар арилгуулсан.Илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 6 аж ахуйн | 97.7% |
| | | | Зөрчил шийдвэрлэлт (хувиар) | 68% | 72% | | |
| | | | Хүсэлтийн шийдвэрлэлт (хувиар) | 94% | 97% | | |
| | | | Стандартын шаардлага | гараагүй | Гаргахгүй ажиллах | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хангаагүй дээжийн хувь (нян судлал) | | | нэгжид 41 заалттай 6 албан шаардлага өгч, 22 заалттай 4 албан шаардлагын биелэлт 53.6%-тай, 14 заалттай 2 албан шаардлагын биелэлт ирүүлэх хугацаа болоогүй байна. Зураг төсөл нь эрүүл ахуйн шаардлага хангасан тухай улсын байцаагчийн 44 дүгнэлт, 26 барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авахыг зөвшөөрөн, 1 зураг төслийг буцааж, 4 барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авахаас татгалзсан. 1 аж ахуйн нэгжийн барилгын зураг төслийн зөрчлийн шинжтэй үйлдэлд зөрчлийн хэрэг нээж, 3000 мянган нэгжээр торгууль оногдуулан, бүрэн барагдуулсан.<br>Урьдчилан сэргийлэх 4 хяналт шалгалтын хүрээнд ундны усны-64, агаарын-11, гадаргуугийн арчдасны 41, өрмийн-2, ариун материалын-9, хөрсний-7, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн-49 нийт 183 дээж авч шинжлүүлэхэд нийт 159 дээж буюу 86.8% нь эрүүл ахуй, аюулгүй үзүүлэлтийн шаардлага хангасан, 5 дээж эрүүл ахуй аюулгүй үзүүлэлтийн шаардлага хангаагүй тул зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж байна.Ундны усны-12, хөрсний-7 нийт 19 дээжний хариу хүлээгдэж байна.<br>Хөрсний шинжилгээний дүн гараагүй тул дунд, их бохирдолтой дээжийн эзлэх хувийг тооцох боломжгүй байна.<br>Ундны усанд нян судлалын үзүүлэлтээр стандартын шаардлага хангаагүй дээж илрээгүй.<br>Нийт 3 хуулийн 20 заалтын хэрэгжилт дунджаар 87.5%-тай хэрэгжиж байна. | |
| | | | Хууль тогтоомжийн хэрэгжилт (хувиар) | 68% | 70% | | |
| | | | Хөрсний дунд, их бохирдолтой дээжийн эзлэх хувь | 14.5% | 13.5% | | |
| 8.3.4 | Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн $5^{2}$.1-д зааснаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэрээр | Улсын төсөв | Ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь | 94% | 96% | Согтууруулах ундааны хүсэлт ирүүлсэн 43 аж ахуйн нэгж, тамхи худалдан борлуулах хүсэлт ирүүлсэн 5 иргэн, 33 ААН, мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл явуулах хүсэлт ирүүлсэн 2 иргэн, 2 ААН, иргэний өргөдөл, гомдлоор 5, удирдах дээд байгууллагын шийдвэрээр 4, хүүхдийн хоол үйлдвэрлэл явуулах хүсэлт ирүүлсэн 1 төрийн байгууллага, | 91.8% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төлөвлөгөөт бус шалгалт хийнэ. | | | | | 445-р нээлттэй хорих ангиас ирүүлсэн 1 хүсэлт, Шарын гол сумын ЭМТ-с ирүүлсэн 1 хүсэлт, нийт 81 ААНБ-ын хүсэлт, 12 иргэний хүсэлт, өргөдлийг хүлээн авч 100% шийдвэрлэсэн.<br>Төлөвлөгөөт бус хяналт шалгалтанд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх 43 ААН, тамхи худалдах 5 иргэн, 33 ААН, сургууль орчмын худалдаа эрхлэгч 25 аж ахуйн нэгж, 2 иргэн, 27 ЕБС, зочид буудал, дэн буудлын үйл ажиллагаа эрхлэгч 23 ААН, 5 иргэн, 445-р нээлттэй хорих анги, нэгдсэн эмнэлэг, 18-р цэцэрлэг, Шарын гол сумын ЭМТ, хүнсний худалдаа эрхлэгч 28 ААН, 10 иргэн, хоол үйлдвэрлэл эрхлэгч 1 ААН, оёдлын цехийн 1 ААН, хүнсний үйлдвэрийн 1 ААН, нийт 186 ААН, 22 иргэний 186 обьект хамрагдсан.<br>Төлөвлөгөөт бус хяналт шалгалтаар нийт 667 зөрчил дутагдал илрүүлэн 475 зөрчил буюу 71.2%-ийг шалгалтын явцад арилгуулан, 1 ААН-ийн дэн буудлын үйл ажиллагааг улсын байцаагчийн актаар түр зогсоож, зөрчлийг арилгуулан, үйл ажиллагааг сэргээсэн акт үйлдсэн. Зочид буудлын 5 ААН-д 85 заалттай 5 зөвлөмж, зөрчил гаргасан 7 ААН-д 43 заалттай албан шаардлага өгч биелэлтийг 86%-тай хангуулсан.<br>Маркет гейт ХХК-иас нэр бүхий цувралын дугаартай Nan нэрийн сүүн тэжээлд цереулид токсин илэрсэн байж болзошгүй гэсэн мэдээллийн дагуу ЭМЯ-ны СХШДАГ-аас өгсөн чиглэлийн хүрээнд 2 худалдааны газрын нийт 4 цувралын дугаар бүхий 2 нэр төрлийн 93 ширхэг Nan нэрийн бүтээгдэхүүнийг битүүмжлэн нийлүүлэгч ААН-д нь буцаах арга хэмжээ авсан.<br>Сургуулийн орчмын хүнсний худлдаа эрхлэгч 2 иргэний худалдаалж байсан хүнсний бүтээгдэхүүнээс-6, үдийн хоол хөтөлбөрийн хүрээнд 3 сургуулийн олгож байгаа хоол болон сургуулийн орчинд худалдан борлуулж байгаа 9 нэр төрлийн хоолноос 9 дээж нийт 15 дээжийг | |
| | | | Зөрчил шийдвэрлэлт (хувиар) | 80.5% | 85% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шинжлүүлэхэд эрүүл ахуй, аюулгүй үзүүлэлтийн шаардлага хангасан. Дотоод хяналтаа хэрэгжүүлэн ажиллаагүй 1 төрийн байгууллагад хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулан 1000 мян.төгрөгийн торгууль оногдуулан барагдуулсан. | |
| ***Эрүүл мэндийн салбарын удирдлага, зохион байгуулалт, ил тод байдал: 3 зорилт 10 арга хэмжээний хэрэгжилт дунджаар 97.2%-тай байна.*** | | | | | | | |

Эрүүл мэндийн газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 чиглэл , 18 зорилт, 73 арга хэмжээг төлөвлөсөн.

ХЭРЭГЖИЛТ: 93.4 %

**ТАЙЛАН НЭГТГЭСЭН:**

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ МЭДЭЭЛЛИЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Ч.МӨНХЦЭЦЭГ

**ҮНЭЛГЭЭ ХЯНАСАН:**

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ МЭДЭЭЛЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Б.ЗОЛБАЯСАХ

**ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН**

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА Б.ЭРДЭНЭТУЛГА

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН БАЙГУУЛЛАГЫН ӨӨРИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ НЭГТГЭЛ**

2026 оны 6 дугаар сарын 11-ны өдөр

| Хэрэгжилт | | Бүгд | Чиглэл | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ | Эмнэлгийн тусламж үйлчилгээ | Хүний нөөцийг чадавхижуулах, нийгмийн баталгааг хангах | Эрүүл мэндийн санхүүжилт | Эрүүл мэндийн технологи | Эмзүйн тусламж үйлчилгээ | Мэдээллийн технологи | Эрүүл мэндийн салбарын удирдлага, зохион байгуулалт, ил тод |
| Зорилтын тоо | | **18** | 2 | 6 | 2 | 1 | 1 | 1 | 2 | 3 |
| Арга хэмжээний тоо | | **73** | 19 | 22 | 9 | 3 | 1 | 5 | 4 | 10 |
| Үнээс | 85 буюу түүнээс дээш “Бүрэн хангалттай” | **58** | 11 | 20 | 6 | 3 | 1 | 4 | 4 | 9 |
| | 70-85 хүртэл хувь “Хангалттай” | **14** | 7 | 2 | 3 | - | - | 1 | - | 1 |
| | 70 хүртэл хувь “Хангалтгүй” | **1** | 1 | - | - | - | - | - | - | - |
| | Хэрэгжилтийн хувь | **93.4** | 86.6 | 90.8 | 88.8 | 96.5 | 100 | 92.6 | 95 | 97.2 |
| | Хэрэгжилтийн оноо | **4.67** | 4.33 | 4.54 | 4.44 | 4.82 | 5.00 | 4.63 | 4.75 | 4.86 |

Эрүүл мэндийн газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 чиглэл , 18 зорилт, 73 арга хэмжээний хэрэгжилт **93.4 %-**тай байна.